



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН 2018 ОНЫ УЛСЫН НЭГДСЭН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2019 он

Хянан тохиолдуулсан: Р.Ганхуяг – ЗУХАГ-ын дарга
П.Баянтүмэн – КХ-ийн дарга

Эмхэтгэсэн: Х.Энхжаргал – КХ-ийн ахлах мэргэжилтэн

Тайлан гаргасан: Х.Оюунбаяр - КХ-ийн ахлах мэргэжилтэн
Х.Энхжаргал – КХ-ийн ахлах мэргэжилтэн
П.Нямдаваа - КХ-ийн ахлах мэргэжилтэн
Ж.Баянмөнх – КХ-ийн мэргэжилтэн
С.Өлзийбуян - КХ-ийн мэргэжилтэн
Э.Чинзолбоо - КХ-ийн мэргэжилтэн
О.Бат-Эрдэнэ - КХ-ийн мэргэжилтэн
О.Дөлгөөнтуул – ЗУХАГ-ын ахлах мэргэжилтэн
Б.Оюуннасан - ЗУХАГ-ын ахлах мэргэжилтэн
Г.Мөнхзул – ССМХ-ийн ахлах мэргэжилтэн
Ц.Ихбаяр – ГЗБХ-ийн мэргэжилтэн
Ж.Энхчимэг – ГЗБХ-ийн мэргэжилтэн

АГУУЛГА

ОРШИЛ	5
1. ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	6
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас хэрэгжүүлсэн томоохон ажлууд	6
1.1.1. Газар зохион байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний чиглэлээр	6
1.1.2. Суурь судалгаа, мониторингийн чиглэлээр	12
1.1.3. Газрын кадастр, мэдээллийн сангийн чиглэлээр	17
1.1.4. Орон зайн мэдээлэл, технологийн чиглэлээр	28
1.2. Газрын харилцааны салбарын хүний нөөцийн судалгаа	29
1.3. Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар хийсэн хяналт, шалгалт	38
1.4. Өргөдөл, хүсэлт, тэдгээрийн барагдуулалтын судалгаа	41
1.5. Газрын маргаан, түүнийг шийдвэрлэсэн байдал	43
1.6. Газар эзэмших эрх болон өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдлын тайлан	45
1.7. Газрын зах зээлийн тойм	49
1.8. Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын талаарх мэдээ, тайлан	56
1.8.1. Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа	56
1.8.2. Газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалт	59
1.9. Газрын кадастрын судалгаа, хэмжил, зураглал	61
1.10. Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2019 оны төлөвлөгөө	62
1.10.1. Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилт	62
1.10.2. Газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөө	69
1.11. Сууц өмчлөгчдийн холбоонд ашиглуулж буй газрын тайлан	70
2. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАН	72
2.1. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал, газар ашиглалтын төрөлд гарсан өөрчлөлт, шилжилтийн үндэслэл /Маягт ГТ-1, 5/	72
2.1.1. Хөдөө аж ахуйн газар	74
2.1.2. Хот, тосгон, бусад суурины газар	76
2.1.3. Зам, шугам сүлжээний газар	77

2.1.4. Ойн сан бүхий газар.....	78
2.1.5. Усны сан бүхий газар	79
2.2. Улсын тусгай хэрэгцээний газар /МАЯГТ ГТ-4/	80
2.3. Газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдлын тайлан /Маягт ГТ-2/.....	82
2.4. Газрын улсын бүртгэлийн тайлан /Маягт ГТ-3/	84
2.5. ГАЗАРТ УЧРУУЛСАН ХОХИРЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-6/	87
2.5.1.Тариалангийн газар.....	87
2.5.2. Бэлчээрийн газар	88
2.5.3. Хот тосгон, бусад суурин газар.....	89
2.5.4. Ойн сан бүхий газар.....	90
2.5.5. Усны сан бүхий газар	91
2.5.6. Ухагдаж эвдэрсэн газар.....	92
2.6. Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайлан /Маягт ГТ-7/	93
2.6.1. Тариалангийн газар.....	93
2.6.2. Бэлчээрийн газар	93
2.6.3. Хот тосгон, бусад суурины газар.....	94
2.6.4. Ойн сан бүхий газар	95
2.6.5. Усны сан бүхий газар	95
2.7. Газрын төлбөр ногдуулалт, төлөлт /Маягт ГТ-8/.....	96
2.8. Газар өмчлөлийн тайлан /Маягт ГТ-9/	102
3. ДҮГНЭЛТ	106

ОРШИЛ

Монгол Улсын Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангилал бүрийн газрын тоо бүртгэл, газрын улсын бүртгэл, шилжилт хөдөлгөөн, газарт учирсан хохирол, газар хамгаалах, нөхөн сэргээх талаар авсан арга хэмжээ, газрын төлбөр ногдуулалт, төвлөрүүлэлт зэрэг үзүүлэлтийг засаг захиргааны нэгж тус бүрээр тусган Улсын газрын нэгдмэл сангийн тайланг гаргаж, Засгийн газарт танилцуулж байхаар Монгол Улсын Газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2.6-д заасан билээ. Уг заалтын дагуу аймаг, нийслэлийн 2017 оны газрын нэгдмэл сангийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын нэгдмэл сангийн тайлан гаргах журам” болон Засгийн газрын 2003 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан тайлангийн ГТ1-9 маягын дагуу нэгтгэн танилцуулж байна.

Газрын нэгдмэл сангийн улсын тайлан нь тайлангийн хугацаанд газрын ангилал болон газар өмчлөл, эзэмшил, ашиглалтын эрх зүйн байдал, тэдгээрт гарсан өөрчлөлтөд дүгнэлт өгөх, газрын талаар авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг тодорхойлох, цаашид газрыг өмчлөх, эзэмших, ашиглах, хуваарилах, хамгаалах, нөхөн сэргээх болон газар зохион байгуулалтын бусад арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, газрын нэгдмэл сангийн өгөгдөхүүнд өөрчлөлт оруулах, улс, орон нутгийн статистик мэдээнд ашиглахад суурь материал болдог ач холбогдолтой.

1. ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛСЭН ТОМООХОН АЖЛУУД

1.1.1. Газар зохион байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний чиглэлээр.

Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө

2003 онд Газрын тухай хуулийг шинэчлэн баталснаар Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг анх боловсруулан Засгийн газраар батлуулсан бөгөөд түүнээс хойш хууль, эрх зүйн орчны өөрчлөлт, өнөөгийн нийгэм, эдийн засгийн өсөлт, орчин үеийн дэлхийн нийтийн хөгжлийн чиг хандлага, газрын харилцааны нөхцөл байдал өөрчлөгдөн Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэх шаардлага бий болсон.

Энэхүү хэрэгцээ шаардлагыг харгалзан 2015 оноос Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг нийгэм, эдийн засаг, газрын харилцааны өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан тодотгох ажлыг эхлүүлэн 2018 онд Газрын шинэтгэлийн Үндэсний хорооны анхдугаар хуралдаанаар төслийг хэлэлцүүлэн дэмжигдэж, улмаар Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 384 дүгээр тогтоолоор батлуулсан.

Энэ удаагийн УГЗБЕТ-ний тодотгол нь Газрын тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн хариуцлагатай газар ашиглалтыг бий болгох, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлэх, газрын нөхцөл, нөөцийг оновчтой ашиглах зэрэг үйл ажиллагааг газрын менежментийн нэгдсэн бодлогоор хангах зорилго бүхий 2025 он хүртэл хэрэгжүүлэх баримт бичиг юм.


Уг төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан болно. Үүнд:

- “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д тулгуурлах;
- Монгол Улсын газрын бодлого нэгдсэн байх;
- Салбар хоорондын уялдааг хангуулахын зэрэгцээ бусад салбарууд нь газар, түүний нөөцийг ашиглаж үйлдвэрлэл, техникийн удирдлага, зохион байгуулалтыг эрхлэх;
- Газар бол өмч, хөрөнгө, эдийн засаг, улс орны хөгжлийг дэмжих суурь гэх талаас нь төлөвлөх.

Шинэчлэн боловсруулсан Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний ач холбогдол нь:

1. Хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, амьдралын чанар, эко системийн тэнцвэр, байгаль орчныг хамгаалах;
2. Улаанбаатар хотоос орон нутагт ажиллаж, амьдрах иргэдэд хүртээмжтэй байдлаар газрыг хуваарилах;
3. Экспортыг дэмжих, импортыг орлох, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

4. Үйлдвэрлэл, борлуулалтын өртгийн сүлжээний цогц уялдааг хангаж, нутаг дэвсгэр, үйлдвэр технологийн кластерын зарчмаар хөгжих тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдсэн.



Зураг 1.1.1.1: Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Хөдөө аж ахуйн газрын төлөвлөлт

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичгийг манай байгууллагаас 2015 оноос эхлэн санаачлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар Улсын хэмжээнд нийт 19 аймгийн 51 суманд Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулаад байна.

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө нь аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд боловсруулсан сумын нийт нутгийг хамарсан газар зохион байгуулалт, газрын нөөцийн менежментийн 5-7 жилийн баримжаатай дунд хугацааны төлөвлөгөөний баримт бичиг юм.


Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 5.2.4.5-т 9.0 тэрбум төгрөгөөр Улсын хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд сумын онцлогоос хамаарч нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг боловсруулахад 1 суманд 30-67 сая төгрөг шаардагдаж байна.

Цаашид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 2020 гэхэд нийт 330 сумыг Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичигтэй болгохоор тусгагдсан бөгөөд энэхүү ажлыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Уг ажил хэрэгжсэнээр сумын түвшинд газар зохион байгуулалт, газрын харилцааны талаар баримтлах албан ёсны төлөвлөлтийн баримт бичигтэй болох бөгөөд үр дүнд нь нутгийн иргэд газар нутгаа үр ашигтай, зүй зохистой ашиглах суурь нөхцлийг бүрдүүлэх юм.

2018 онд 13 аймгийн 38 суманд сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил хийгдсэнээс 27 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө батлагдан хэрэгжиж эхлээд байгаа бөгөөд үлдсэн сумдын хувьд хэлэлцүүлэг, судалгааны шатандаа явагдаж байна. Эдгээр 27 сумдаас Дундговь аймаг аймгийнхаа нийт сумдад нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө болон аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг хамтад нь зохион байгуулж аймаг, сумын ИТХ-аар батлуулсан байна.

2019 онд сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг Архангай, Булган, Баянхонгор, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий аймгуудад нийт 32 суманд орон нутаг болон гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр зохион байгуулахаар төлөвлөөд байна.




Зураг 1.1.1.2: Булган аймгийн Сэлэнгэ сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө

“Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим, систем байгуулах” ажил

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ лавлагааны цахим, систем байгуулах” ажлыг 2018 оноос эхлүүлээд байгаа бөгөөд уг системийг 2019 оны 4 дүгээр улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Улсын хэмжээнд мөрдөгдөж буй бүх шатны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон бусад салбарын төлөвлөгөөг нэгтгэсэн нэгдсэн мэдээллийн сан бий болох бөгөөд уг мэдээллийн сангаар дамжуулан иргэд олон нийтэд газар зохион байгуулалтын талаарх мэдээллээр үйлчлэх юм.

ДИНАМИК, ИНТЕРАКТИВ, БОДИТ ЦАГИЙН ШИНЭЧЛЭЛ БҮХИЙ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЦАХИМ СИСТЕМ



Зураг 1.1.1.3: Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний цахим системийн бүтцийн схем.

Энэхүү вебд суурилсан цахим систем бий болсноор Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих бүхий л үйл ажиллагаанд иргэд, олон нийт орон зай, цаг хугацаа хамаарахгүйгээр нээлттэй оролцож, саналаа өгөх, мэдээлэл авах боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл иргэд хүссэн газрынхаа талаар иж бүрэн мэдээллийг авах, амьдарч буй газрынхаа цаашдын төлөвлөлт зохион байгуулалтад өөрийн саналаа оруулж, түүндээ хяналт тавих боломжтой болох юм.

Мөн төлөвлөгөөг улсын хэмжээнд нэг стандартын дагуу, нэгдсэн хяналттайгаар боловсруулах боломжтой болно. Үр дүнд нь төлөвлөлтгүй, эмх замбараагүй, хууль бус газар олголт зогсож, газрын зөрчил маргаан буурч, салбар хоорондын уялдаагүй байдал арилна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах

2018 онд ГЗБГЗЗГ-аас газар өмчлөлийн чиглэлээр хэд хэдэн томоохон ажлыг зохион байгуулж ажиллалаа. Тухайлбал “Газрын харилцааны ажилтны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлж эхэлсний 15 жилийн ойг тохиолдуулан Барилга, хот байгуулалтын яам болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлсний үр дүн, цаашдын зорилт” сэдэвт үндэсний форумыг 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан юм.

Энэхүү форумгаар Монгол Улсын иргэнд газар өмчлүүлж эхэлснээс хойших 15 жилийн хугацаанд олсон ололт амжилт, алдаа оноог судалгаа, шинжилгээний үндсэн дээр дүгнэн ярилцаж, цаашид газрын харилцааны салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрийн болон мэргэжлийн байгууллагуудын хариуцлагыг сайжруулах, газар өмчлөлийн үйл ажиллагааг иргэдэд нээлттэй ил тод байлгах, хот байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөлтөд хамрагдсан, инженерийн дэд бүтэц бүхий газрыг иргэдэд өмчлүүлэн хөрөнгө оруулалт хийх, амьжиргааны эх үүсвэрээ нэмэгдүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэв.



Зураг 1.1.1.4: “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлсний үр дүн, цаашдын зорилт” сэдэвт үндэсний форумын оролцогчид.

Уг форумд Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Барилга, хот байгуулалтын яам, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам, тээврийн хөгжлийн

ям, Шинжлэх ухааны академи, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн газар /хуучин нэрээр/, нийслэл, дүүргийн Газрын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, салбарын төрийн бус болон мэргэжлийн байгууллагуудыг төлөөлөн 150 гаруй төрийн албан хаагч, мэргэжилтэн, эрдэмтэн, судлаач, оюутнууд оролцож, хэвлэл, мэдээллийн 22 байгууллагаас мэдээ, сурвалжлага бэлтгэн олон нийтэд хүргэлээ.

Мөн 2018 онд газар өмчлөлийн чиглэлээр хийгдсэн нэг томоохон ажил бол БХБЯ, ГЗБГЗЗГ-аас Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан Монгол Улсын Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэн Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэгүй өмчлүүлэх хуулийн заалтын хугацааг 2028 он хүртэл буюу 10 жилээр сунгуулсан явдал юм.

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 130 дугаар тогтоолоор нийт 80922 иргэнд 8635 га газрыг өмчлүүлэхээр төлөвлөснөөс 44683 иргэнд 4450.08 га газрыг өмчлүүлж Засгийн газрын 130 дугаар тогтоолын хэрэгжилт 60.99 хувиар хангагдсан бөгөөд 2017 оны хэрэгжилттэй харьцуулахад 18.23 хувиар өссөн байна.

2018 онд улсын хэмжээнд 8635.8 га газрыг өмчлүүлэхээр төлөвлөж байсан бол 2019 онд 5820.52 га газрыг иргэнд өмчлүүлэхээр төлөвлөсөн нь өмчлөлийн газрын төлөвлөлт оновчтой болж, тэнд инженерийн болон нийгмийн дэд бүтцийг бий болгож иргэдийн амьдрах орчин шаардлага хангасан байхаар төлөвлөх эхлэл тавигдаж байгаагийн илрэл юм.

2018 онд нийт 4450.08 га газрыг 44683 иргэнд өмчлүүлж, өссөн дүнгээр 615454 иргэн 62217.34 газар өмчилсөн нь нийт иргэдийн 19.4 хувь нь болж өмнөх оноос 1.1 хувиар өссөн байна.

Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалт

Барилга, хот байгуулалтын яамтай хамтран “Хилийн цэсийн маргааныг шийдвэрлэх санал боловсруулах ажлын хэсэг байгуулах” тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсний дагуу Засгийн газрын 2018 оны 89 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулагдан тодорхой асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэн ажиллаж байна.

Ажлын хэсгийн анхдугаар хуралдааныг 2018 оны 5 дугаар сард зохион байгуулсан бөгөөд Улсын хэмжээний хилийн цэсийн маргааны өнөөгийн байдал, үүсэх болсон шалтгаан, шийдвэрлэх арга замыг танилцуулан хэлэлцүүлсэн.

Тус хуралдаанаас бодит бус маргаан үүссэн Увс, Төв, Дархан-Уул аймгуудын маргаануудад тайлбар, албан бичиг хүргүүлэх шийдвэр гарсны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 01/2206 тоот, ГЗБГЗЗГ-ын 2018 оны 1/957 тоот албан бичгүүдийг тус тус хүргүүлэн ажиллаж, хуулийн хүрээнд маргааныг шийдвэрлэсэн.

Мөн Улсын хэмжээний хилийн цэсийн маргааны асуудлыг Газрын шинэтгэлийн үндэсний хорооны хоёрдугаар хуралдаанд хэлэлцүүлж, үүссэн нөхцөл байдалд 5 үндсэн чиглэлээр тодорхой зөвлөмжүүдийг гаргаж, орон нутагт албан бичгээр хүргүүлж мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.

2018 оны хилийн цэсийн маргааны судалгаанаас үзэхэд нийт 19 аймгийн хэмжээнд их, бага хэмжээний хилийн цэсийн маргаан үүссэн бөгөөд энэ нь нийт сумдын 51.5%-ийг эзэлж байгаа юм.

1996 оноос хойш маргаантай байгаа нийслэлийн Налайх дүүрэг, Төв аймгийн Эрдэнэ сумдын хилийн маргааны асуудлыг шийдвэрлэх санал боловсруулах ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын Сайдын 2018 оны 196 тоот тушаалаар байгуулан 2018 оны 11 дүгээр сард анхдугаар хурлыг зохион байгуулж холбогдох талуудын саналыг харгалзан үзэж цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг боловсруулж тодорхой чиглэлүүдийг талуудад хүргүүлж ажиллалаа.

Газар зохион байгуулалтын ажлын үнэлгээ

2018 онд Засгийн газраас газрын харилцааны талаар гаргасан томоохон шийдвэрүүдийн нэг нь 2009 онд Засгийн газрын тогтоолоор батлагдаж байсан “Газар зохион байгуулалтын ажлын үнэлгээ”-г шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 320 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлуулсан явдал юм. Хуучин мөрдөж байсан ажлын үнэлгээ нь ажлын үе шат, түүнд хамаарах ажлуудын зардлыг тооцолгүй зөвхөн талбайн хэмжээгээр нэг үнэ тогтоосон нь бодит зардлаас ихээхэн зөрүүтэйгээс хүндрэл үүсч байсан.

Газрыг бүртгэх, тоолох, газрын төлөв байдал, чанарыг үнэлэх, хянах, газар ашиглалтын төлөвлөлт, зураглал боловсруулах, газрыг нөхөн сэргээх зэрэг ажлуудын төсөв, зардлын бодит бус тооцоо нь ажлын чанарт сөргөөр нөлөөлж, газрын зөрчил маргаан гарах, хууль бус үйл ажиллагаа явагдах, газрын чанар, төлөв байдлыг нарийвчлалгүй тогтоож газарт хохирол учруулах зэрэг эрсдлийг бий болгож байсан юм. Иймээс газар зохион байгуулалтын ажлын үнэлгээг шинэчилснээр дээрх хүндрэл, эрсдэлүүдийг арилгаж, ажлын хэмжээ, хүндрэлд нийцсэн бодит үнэлгээг тогтоох нөхцлийг бүрдүүлсэн ач холбогдолтой ажил болсон юм.

1.1.2. Суурь судалгаа, мониторингийн чиглэлээр.


Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа

Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил нь тухайн газрын талбайн өөрчлөлт, үржил шимийн өөрчлөлтийг хянах, тогтоох, газар эзэмшигч, ашиглагч болон эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах, газар эзэмших, ашиглах гэрээний хэрэгжилтийг дүгнэх, шинээр газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг хянан баталгааны мэдээллээр хангах, газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.


Газрын тухай хуульд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг 5 жил тутам хийж байхаар заасан байдаг бөгөөд 2018 онд ГЗБГЗЗГ нь тариалан болон атаршсан газрын, хот суурин газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг урсгал төсвийн санхүүжилтээр зохион байгууллаа.

2017, 2018 онд улсын хэмжээнд тариалангийн болон атаршсан газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг зохион байгуулж дууслаа. Тодруулбал, 2017 онд Сэлэнгэ, Дорнод, Булган, Төв аймгийн нийт 858315.0 га, 2018 онд 17 аймгийн /Архангай, Дархан-Уул, Орхон, Хөвсгөл, Нийслэл, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Ховд, Баян-Өлгий, Увс, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр,

Хэнтий, Сүхбаатар/ болон нийслэлийн нийт 469214.8 га тариалан болон атаршсан газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.




Зураг 1.1.2.1: Тариалан болон атаршсан газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа /2017-2018 он/



Зураг 1.1.2.2: Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зураг

2018 онд Архангай, Баянхонгор, Сүхбаатар, Хэнтий аймгийн бүх сумдын нийт 78186.71 га хот тосгон, бусад суурин газрын хянан баталгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.



Зураг 1.1.2.3: Хот тосгон, бусад суурин газрын хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зураг

Уг хянан баталгааны ажлын хүрээнд улсын хэмжээнд тариалан, атаршсан болон хот суурин газрын төлөв байдал, чанар хэрхэн өөрчлөгдсөнийг тогтоох боломжтой болсон бөгөөд эдгээр өөрчлөлтийг үндэслэн газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж байгаа юм.

Мөн үүнээс гадна нэг хийгдсэн томоохон ажил бол бэлчээр, тариалан, хот тосгоны газар, захиалгат хянан баталгааны ажлын аргачилсан зааврыг Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 34 дүгээр тушаалаар батлуулж, мөрдөхөд бэлэн боллоо.

Эдгээр зааврыг хянан баталгааны ажилд мөрдсөнөөр мэдээллийг нэг стандартаар хүлээн авах, нийтийн хэрэглээнд гаргах, харьцуулалт хийх боломжийг бүрдүүлэх, хянан баталгааны ажлыг цахимжуулах, хяналтыг сайжруулах, мэргэжлийн байгууллагууд болон орон нутгийн газрын асуудал эрхэлсэн байгууллагын мэргэжилтнүүдийг нэгдсэн аргачлалаар хангахад чухал ач холбогдолтой юм.




Зураг 1.1.2.4: Бэлчээр, тариалан, хот тосгон, захиалгат хянан баталгааны ажлын аргачилсан зааврууд

Бэлчээрийн газрыг фотомониторингийн аргаар үнэлэх

Бэлчээрийн газрыг фотомониторингийн аргаар үнэлэх нь улсын хэмжээнд бэлчээрийн газрын төлөв байдал, доройтлын зэрэглэлийг тогтоох, хянах, бэлчээр ашиглалтыг төлөвлөхөд чухал ач холбогдолтой юм.

Энэхүү ажлыг 2015 оноос ГЗБГЗЗГ, “Бэлчээр ногоон алт” төсөлтэй хамтран улсын хэмжээнд хэрэгжүүлж байгаа бөгөөд холбогдох журам, аргачлалыг боловсруулан батлуулах, гарын авлага, багаж хэрэгслээр хангах, сургалт зохион байгуулах зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна.

2018 онд 21 аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын инженер хайгуул, мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан сургалтыг зохион байгуулсан бөгөөд Дундговь /15/, Орхон /2/, Ховд /19/, Баян-Өлгий /14/, Хэнтий /18/, Өмнөговь /15/, Булган /16/ аймгийн ГХБХБГ-ны нийт 99 мэргэжилтэн хамрагдсан байна.



Зураг 1.1.2.5: Бэлчээрийн газрын фотомониторингийн цэгийн байршил ба сэргэх чадавхийн ангилал

Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер программ хангамжид 2017 онд 2418 цэгийн мэдээллийг оруулж байсан бол 2018 онд 4615 цэгийн мэдээллийг орууллаа.

Бэлчээрийн газрын фотомониторингийн ажлын үр дүнг олон нийтэд хүргэх зорилгоор 2017 оноос байгууллагын орон зайн мэдээллийн санд байршуулж эхэлсэн. Энэ мэдээллийн санд аймаг, сум, баг, бэлчээр ашиглалтын хэсгийн нэр, судалгаа хийсэн огноо, газрын нэр, улирлын бэлчээр, цэгийн солбицол, ургац, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ, бүсийн нэр, сэргэх чадварын ангилал зэрэг мэдээлэл багтаж байна.

Газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээ байгуулах

Газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээ байгуулах ажлын даалгавар, зардлын тооцоог боловсруулж, тус газрын 2018 оны 1 дүгээр сарын 18-ны 2/130 тоот албан бичгээр БХБЯ-нд хүргүүлж, 2018/06 тоот ажлын даалгаврыг БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар 2018 оны 3 сарын 6-ны өдөр батлуулсан.

Уг ажлын тендерт газрын мэргэжлийн байгууллага "АТТП" ХХК шалгарсан бөгөөд ажил гүйцэтгэх гэрээний төслийг боловсруулж, БХБЯ-ны 2018 оны 10 сарын


30-ны өдрийн 2018/220 тоот гэрээг байгуулсан. “АТТП” ХХК 2018 оны 11 сарын 19-ний өдрийн 141 тоот албан бичгээр эхлэлийн шатны тайланг ирүүлсэн бөгөөд энэхүү тайланд захиалагчийн хяналт хийлээ.

Энэ ажлын зорилго нь Улсын хэмжээнд газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын газарт газрын төлөв байдал, чанарын мониторингийн цэг, сүлжээг байгуулж, салбар хоорондын мэдээлэл солилцооны уялдааг хангасан, вэбэд суурилсан цахим мэдээллийн системийг бий болгон, газар хамгаалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Гэрээт ажил 2019 онд хийгдэж дуусна.

1.1.3. Газрын кадастр, мэдээллийн сангийн чиглэлээр.

Газрын нэгдмэл сангийн тооллого, тоо бүртгэл

Газар зүйн мэдээллийн системийн программ хангамжийг ашиглан 2009-2011 онд хийж гүйцэтгэсэн газрын нэгдмэл сангийн тооллого, тоо бүртгэлийн ажлын тоон мэдээллийг хиймэл дагуулын зураг /2013-2014 оны SPOT-5, 2015 оны Ландсат-8/, 1:100000 масштаб бүхий байр зүйн зургийн тодотгол, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг солбицолжуулах ажлын үр дүн, улсын тусгай хэрэгцээний газрын болон “Ойн сан бүхий газрын мэдээллийн сан бүрдүүлэх ажил”-ын тоон мэдээллийг ашиглан 21 аймаг, нийслэлийн хэмжээнд шинэчлэн улсын хэмжээнд нэгтгэх ажлыг хийж гүйцэтгэлээ.



Зураг 1.1.3.1: Монгол орны газрын нэгдмэл сангийн ангиллын зураг

Газрын тухай хуулийн холбогдох заалтын дагуу газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын хэмжээ, байршлыг Засгийн газраар батлуулахаар дээрх ажлыг үр дүнг Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлээд байна.

Иргэд олон нийт, мэргэжлийн байгууллагуудыг мэдээллээр хангах зорилгоор Монгол Улсын газрын нэгдмэл сангийн ангилал, тайлан, түүнтэй холбоотой бүх төрлийн мэдээллийг товхимол болгон жил бүр хэвлүүлэн нийтийн хүртээл болгож байна.



Зураг 1.1.3.2: Газрын нэгдмэл сангийн тайлангийн товхимлууд

Газрын үнэлгээ

Газрын төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолоор “Монгол Улсын газрын нэгдмэл сангийн үнэлгээний тойргийн хуваарь”, “Хот тосгон, бусад суурины газрын зэрэглэл, тэдгээрийн нэг га-ийн суурь үнэлгээ”, “Хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог бүрийн 1 га-ийн суурь үнэлгээ”-г тус тус баталж, өнөөг хүртэл 21 жил дагаж мөрдөж байсан.

Энэхүү газрын суурь үнэлгээ нь зөвхөн төлбөр, татвар авах зориулалттай бөгөөд зах зээлийн бодит байдалтай нийцэхгүй байх /тухайлбал: 1997 онд 1 кг гурил 363 төгрөг, 1 ширхэг талх 236 төгрөг, 1 л АИ-80 бензин 210 төгрөг байсан бол 2016 онд 1 кг гурил 1120 төгрөг, 1 ширхэг талх 1156 төгрөг, 1 л АИ-80 бензин 1458 төгрөг болж даруй 6 дахин нэмэгджээ/, газар зүйн байршил, газар ашиглалтын зориулалттай уялдаагүй байх зэргээс үүдэн газрын төлбөр, татвар, газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ, газрын нөхөх олговрын үнэ, бэлэглэх, барьцаалах, даатгуулах, газар ашиглалтын зөв оновчтой төлөвлөлтийг хийх, албан ёсны тайлан, мэдээ боловсруулах зэрэг үйл ажиллагаанд хүндрэл гарч байсан.

Иймд Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолоор батлагдсан газрын суурь үнэлгээг газрын үнэлгээний хэрэглээний олон төрөлд нийцүүлэн өөрчлөх шаардлагын улмаас Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 182 дугаар тогтоолоор шинэчлэн баталлаа.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 6 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 182

Улаанбаатар
хот

Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс),
суурь үнэлгээ, газрын төлбөрийн
хэмжээг тогтоох тухай

Газрын төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Чөлөөт бүсийн тухай хуулийн 22.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь.


1. "Газрын үнэлгээний тойрог"-ийг 1 дүгээр хавсралт, "Хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойргийн 1 га газрын суурь үнэлгээ"-г 2 дугаар хавсралт, "Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн газрын үнэлгээний зэрэглэл (бүс), 1 га газрын суурь үнэлгээ"-г 3 дугаар хавсралт, "Аймгийн төвийн сум, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Өвөрхангай аймгийн Хархорин, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Сэлэнгэ аймгийн Мандал, Алтанбулаг, Завхан аймгийн Тосонцэнгэл, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төв (хот, тосгон, бусад суурин газар)-ийн газрын үнэлгээний зэрэглэл (бүс), 1 га газрын суурь үнэлгээ"-г 4 дүгээр хавсралт, "Чөлөөт бүсийн 1 га газрын суурь үнэлгээ"-г 5 дугаар хавсралт, "Бусад сумын төв (хот, тосгон, бусад суурин газар)-ийн газрын үнэлгээний зэрэглэл (бүс), 1 га газрын суурь үнэлгээ"-г 6 дугаар хавсралт, "Зам, шугам сүлжээний газрын төлбөр"-ийг 7 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Нэг хонин толгойд ногдуулах бэлчээрийн газрын төлбөрийг түүний тогтоосон суурь үнэлгээний 0.03 хувь, үр тариа, төмс хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалагийн зориулалттай нэг га газрын төлбөрийг түүний тогтоосон суурь үнэлгээний 0.03 хувь, нэг га хадлангийн газрын төлбөрийг түүний суурь үнэлгээний 0.01 хувь, хот, тосгон, бусад суурин нэг га газрын төлбөрийн хэмжээг түүний суурь үнэлгээний 0.1-1.0 хувь, чөлөөт бүсийн 1 га газрын төлбөрийг түүний суурь үнэлгээний 1.0 хувь байхаар тус тус тогтоосугай.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаагаас бусад төрийн өмчийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын арга хэмжээнд шаардагдах зардлыг газрын төлбөрийн орлогоос зохих журмын дагуу жил бүрийн төсөвт тусган батлуулах, зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд үүрэг болгосугай.

2

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Газрын төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1997 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 152 дугаар тогтоол, "Тогтоолд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 291 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ


Барилга, хот байгуулалтын сайд


Х.БАДЕЛХАН

Зураг 1.1.3.3. Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол

Газрын суурь үнэлгээг шинэчлэн тогтоохдоо:

1. Газрын нэгдмэл сангийн үнэлгээний бүсийг байгаль, нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлалыг үндэслэн хуучин 4 тойрог байсныг 31 тойрог болгон нарийвчилсан.






Зураг 1.1.3.4: Газрын суурь үнэлгээний тойрог

2. Газрын үнэлгээний 31 тойрог /бүс/ тус бүрт харгалзах хөдөө аж ахуйн газрын суурь үнэлгээг тариалан, хадлан, бэлчээр гэсэн газар ашиглалтын 3 зориулалтаар газар зүйн байршил болон газрын үржил шим, өгөөжөөс үүсэх ялгаварт орлого зэргийг харгалзан ялгавартайгаар тогтоосон.




Зураг 1.1.3.5: Газрын нэгдмэл сангийн үнэлгээний бүс, тойрог

3.Төв суурин газрын суурь үнэлгээг тогтоохдоо газрын зах зээлийн үнийн мэдээнд шинжилгээ хийж, түүн дээрээ газрын үнэд нөлөөлөх гол хүчин зүйлүүд болох байршил, инженерийн хангамж, нийгэм, эдийн засгийн болон инженер, геологи, байгаль орчны нөхцөл, ашиглалтын зориулалтыг харгалзан хот, тосгон, суурин газрын үнэлгээний зэрэглэлээр ялгавартайгаар нарийвчлан тогтоосон.



Зураг 1.1.3.6: Хөвсгөл аймгийн Мөрөн сумын гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын суурь үнийн бүсийн зураг



Зураг 1.1.3.7: Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай газрын суурь үнийн бүсийн зураг

Газрын суурь үнэлгээг шинэчлэх тооцооллыг хийхдээ суурь үнийг өсгөхийг чухалчлаагүй бөгөөд суурь үнэлгээг бодитой тодорхойлох, төлбөр татварын уян хатан байх зарчмыг баримталсан бөгөөд Газрын суурь үнэлгээг шинэчилснээр дараах ач холбогдолтой. Үүнд:

1. Газрын үнэлгээг бодитой болгосноор газрын төрөл хэсгүүдийн чанар байдал, эдийн засгийн чадавх, байршлын хувьд ямар ач холбогдолтой, ямар түвшинд байгаа талаар бүрэн мэдээлэлтэй болж үйлдвэрлэл үйлчилгээг зөв байршуулах, тариалангийн газрыг зөв сонгох, ашиглалтыг төлөвлөх, газрын менежментийг боловсруулах, газрын төлөв байдал чанарын өөрчлөлт, доройтлыг тогтоож түүнийг нөхөн сэргээх арга хэмжээ авах, газрын эдийн засгийн харилцааг сайжруулах;

2. Газрын үнэлгээг шинэчлэх нь газрын бодитой үнийг тодорхойлох, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах хөшүүргийг бий болгох;

3. Газрын үнэлгээг ялгаатай болгосноор газар ашиглалтыг зөв төлөвлөх, газар ашиглалтын тохиромжтой байдлыг эдийн засгийн үзүүлэлтээр тодорхойлох, түүнээс үндэслэн татвар төлбөрийг зөв, уян хатан тогтоох;


4. Газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх зэргээр зөв менежмент хийх үндэс суурь нь тодорхойлогдоно.

Газрын кадастрын мэдээллийн сан

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаас хойш хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд Монгол улсын хэмжээнд геодезийн сууриар баталгаажсан, кадастрын зурган мэдээлэлд суурилсан, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэл, цахимжсан хувийн хэрэг бүхий иргэдийн газар ашиглахтай холбоотой өргөдөл, бүртгэл, түүний шийдвэрлэлтийг автоматжуулсан, иргэд, олон нийтэд нээлттэй, нийгэм, эдийн засгийн олон талт эрэлт, хэрэгцээг хангах Газрын кадастрын мэдээллийн системийг байгуулахаар зорьж ирсэн.


Энэхүү зорилтын хүрээнд 2017-2018 онд Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” программ хангамжийг 21 аймаг, 330 сум, нийслэл 9 дүүргийн хэмжээнд бүрэн нэвтрүүлсэн.

2018-2019 онд хэрэгжиж буй “Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж, засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх” гэрээт ажлын хүрээнд Лэнд менежер программ хангамжийн веб хувилбарыг хөгжүүлэн улсын хэмжээнд үйл ажиллагаанд оруулахад шаардлагатай бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгаа бөгөөд 2019 оны 11 дүгээр сард гэрээт ажил хэрэгжиж дуусахад Лэнд менежер программ хангамжийн веб хувилбарыг Улсын хэмжээнд үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ.



Зураг 1.1.3.8: Лэнд менежер програм хангамжийн веб хувилбар

Мөн иргэд, олон нийтэд Газрын кадастрын мэдээллийн сангийн мэдээллээр онлайнаар үйлчлэх зорилго бүхий <http://www.egazar.gov.mn> цахим хуудсыг хэрэглээнд нэвтрүүлээд байна.



Зураг 1.1.3.9: egazar.gov.mn цахим хуудасны харагдах байдал

“Нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэн засварлаж, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбох, үйлчилгээнд нэвтрүүлэх” төсөл

2018 онд Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар “Нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэн засварлаж, Улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбох, үйлчилгээнд нэвтрүүлэх” төсөл эхлэн хэрэгжиж эхэлсэн бөгөөд тус төсөл нь Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Засгийн газрын гишүүн болон нийслэлийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний гуравдугаар хавсралт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар болон нийслэлийн Засаг даргын хамтран ажиллах үйл ажиллагааны 2017-2020 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажил юм.

Дээр дурдсан нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэн засварлаж, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбох, үйлчилгээнд нэвтрүүлэх төслийг 2018 ны 8 дугаар сарын 17-ны өдөр нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд уг ажиллагаанд Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, нийслэлийн Засаг даргын орлогч П.Баярхүү, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Ц.Ганхүү, нийслэлийн Газрын албаны дарга Э.Болорчулуун болон бусад газар, алба, хэлтсийн дарга нар, мэргэжилтнүүд оролцсон юм.

Төслийн үр дүнд Монгол улсын газар нутаг дээрх бүхий л газар ашиглалтыг бүртгэх, баталгаажуулах, мэдээллийн нэгдсэн санг үүсгэх, бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад нэгдсэн стандарт бүхий баталгаажсан мэдээллээр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран үйлчлэх бодит боломж бүрдэх юм.

Гэрээт ажлын гүйцэтгэгчээр “Геомастер” ХХК ажиллаж байгаа ба 2018 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2019 оны 12 дугаар сарын 1-нийг хүртэлх хугацаанд хэрэгжих юм.




Зураг 1.1.3.10: “Нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэн засварлаж, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбох, үйлчилгээнд нэвтрүүлэх” төслийн нээлтийн үйл ажиллагаа

Газар эзэмших, ашиглах эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаа

Монгол Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганаар Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль шинэчлэн батлагдсанаар аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын газрын даамал нь газар эзэмших, ашиглах эрхийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх үйл ажиллагааг Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер программ хангамжаар дамжуулан цахим хэлбэрээр эрхлэх болсон.

Ингэснээр газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших, ашиглах эрхээ эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхээр Улсын бүртгэл, Газрын албаны хооронд явж, ханддаг байсан явдал үгүй болж зөвхөн харъяа газрын асуудал эрхэлсэн байгууллага буюу аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын газрын даамлаас үйлчилгээгээ бүрэн авах боломжтой боллоо.

Мөн ГЗБГЗЗГ нь дээрх ажлын хүрээнд Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийн санг дахин зохион байгуулах, Лэнд менежер программ хангамжийг хөгжүүлэх, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд холбогдоход шаардлагатай техник болон технологийн асуудлуудыг шийдвэрлэх, “Үндэсний дата төв”-өөр дамжуулан “ХУР” системд холбогдох, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг шинэчлэх, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамалд холбогдох асуудлаар сургалт, чиглэл өгөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.




Зураг 1.1.3.11: Газар эзэмших, ашиглах эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаа

Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” программ хангамжийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэглээнд нэвтрүүлэх

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын удирдлага, мэргэжилтнүүдийн уулзалтыг зохион байгуулж, Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” программ хангамжийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэглээнд нэвтрүүлэх, тэр дундаа нийслэлийн хэмжээнд газрын маргааны дийлэнх хувийг эзлэх болсон Богдхан уулын дархан цаазат газрын мэдээллийн санг Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд холбох асуудлаар шийдэлд хүрлээ.

Тус уулзалтаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамны өгөгдөл мэдээллийг Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд хөрвүүлэн оруулж, “Лэнд менежер” программ хангамжийг ашиглах тухай нэгдсэн тохиролцоонд хүрсэн бөгөөд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын зүгээс шаардлагатай бүхий дэмжлэг, туслалцааг үзүүлэхээр шийдвэрлэсний дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар Богдхан уулын дархан цаазат газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад ашиглуулж буй мэдээлэл Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд баталгаажиж орох бодит боломж бүрдлээ.



Зураг 1.1.3.12: Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын уулзалт


Газрын биржийн цахим систем

Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг газар өмчлөх, эзэмших эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр түргэн, шуурхай, ил тодоор зохион байгуулах, газрын барьцаа, түрээсийн бүртгэл хийх, газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулж нэгдсэн мэдээллийн сан бий болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээ, статистик мэдээллээр иргэд олон нийтэд үйлчлэх, зорилгоор хөгжүүлсэн бөгөөд дараах үндсэн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа;
- Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт;
- Монгол Улсын иргэн газар өмчлөх эрхээ болон иргэн, хуулийн этгээд газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэхтэй холбогдсон арилжаа;
- Монгол улсын иргэн газар өмчлөх эрхээ болон иргэн, хуулийн этгээд газар эзэмших эрхээ бусдад ашиглуулахтай холбогдсон арилжаа;
- Газрын худалдаа, түрээсийн зар мэдээлэл, зуучлалын үйл ажиллагаа;


- Монгол Улсын иргэний газар өмчлөх эрх болон иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийн барьцааны лавлагаа гаргах;
- Газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийн санг эрхлэх, олон нийтэд мэдээлэх;

Уг системийг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газрын алба, 330 сумын Газрын даамлууд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар хэвийн үйл ажиллагааг хангаж, хяналт тавих ажлыг гүйцэтгэж байна.



Зураг 1.1.3.13: Газрын биржийн цахим систем

2018 оны жилийн эцсийн байдлаар Газрын биржийн цахим системд нийт 2566 газрын дуудлага худалдаа, 366 газрын эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 13962 газрын барьцаа, 16056 газрын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ бүртгэж оруулаад байгаа бөгөөд үүнээс тайлант онд 1179 газрын дуудлага худалдаа, 49 газрын төсөл сонгон шалгаруулалт, 11621 газрын барьцааны, 2892 газрын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээний мэдээлэл бүртгэгдсэн байна.



Зураг 1.1.3.14: Тайлант онд зохион байгуулсан дуудлага худалдаа

Уг системээр иргэд, олон нийт өөрийн оролцохыг хүссэн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтандаа байршил харгалзахгүй хамрагдаж, газартай холбоотой мэдээ, мэдээллийг авч газрын худалдаа, түрээсийн зараа оруулж арилжаалах боломжтой юм.

1.1.4. Орон зайн мэдээлэл, технологийн чиглэлээр.

ГЗБГЗЗГ-ын Орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс нь байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтэц байгуулах ажлын хүрээнд “Байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу өгөгдөл, мэдээллийг ангилан зохион байгуулж 35 төрлийн өгөгдлийн сан түүний дотор 141 дэд төрлийн өгөгдлийн сангууд нийт 53ТВ хэмжээтэй өгөгдлийн сан үүсээд байна.

“Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад орон зайн өгөгдлийн дэд бүтцийн гүйцэтгэх үүрэг ач холбогдол” сэдэвт ОУ-ын зөвлөгөөн Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан Дэлхийн Орон зайн мэдээллийн менежментийн санаачилга Зөвлөхүүдийн хорооноос нь дэлхийн хэмжээний тулгамдсан гол асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай орон зайн мэдээллийн 14 суурь өгөгдлийн жагсаалтын дагуу орон зайн өгөгдөл, мэдээллүүдийг ангилан тодорхойлох ажлууд хийгдэж байна.


Түүнчлэн үндэсний хэмжээний орон зайн суурь өгөгдөл, мэдээллийн санг нэгдсэн стандартын дагуу нэгтгэж, геопорталаар дамжуулан веб үйлчилгээг тогтмол хэрэглээнд нэвтрүүлж байгаагийн зэрэгцээ НҮБ-ын Дэлхийн Орон зайн мэдээллийн менежментийн Зөвлөхүүдийн хороотой хамтран “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөгжиж буй орнуудын орон зайн мэдээллийн менежментийн чадавхийг бэхжүүлэх”-1819D төслийг хэрэгжүүлж эхэллээ.



Зураг 1.1.4.1: Байгууллагын орон зайн мэдээллийн дэд бүтэц

1.2. Газрын харилцааны салбарын хүний нөөцийн судалгаа

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Барилга, хот байгуулалтын Сайдын 2018 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 41 дүгээр тушаалаар баталсан стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт заасны дагуу Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар, Газар зохион байгуулалтын хэлтэс, Геодези, зураг зүйн хэлтэс, Суурь судалгаа, мониторингийн хэлтэс, Кадастрын хэлтэс, Орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс, Бүс нутаг, хот төлөвлөлтийн хэлтэс, Хот байгуулалтын кадастрын хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс, Архив, мэдээллийн төв гэсэн нийт 10 нэгж, нийслэлийн Газрын алба, дүүргийн Газрын алба, 21 аймагт Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумдад Газрын даамал гэсэн нэгжтэйгээр ажиллаж байна /Зураг 1.2.1/.



Зураг 1.2.1: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын бүтэц

Газрын харилцааны салбарт нийтдээ агентлагт 86, нийслэл, дүүргийн Газрын албанд 210, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 363, суманд Газрын даамал 361, нийт 1020 албан хаагч ажиллаж байна /Зураг 1.2.2/.



Зураг 1.2.2: Улсын хэмжээнд газрын салбарт ажиллаж байгаа албан хаагчдын тоо


Агентлаг нь ажлын байрны тодорхойлолтын дагуу эрхэлсэн ажлаа мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэх боломжийг бий болгох үүднээс албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж ажиллалаа.

Мөн агентлагийн хэлтсүүд, мэргэжилтнүүд, орон нутгийн харъяа байгууллага, газрын мэргэжлийн байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тухай бүр хариуцсан ажлын чиглэлээр тогтмол өгч ажилласан.

Газрын харилцааны салбарт ажиллагсдын хүний нөөцийн судалгааг насны ангилал, хүйсийн харьцаа, ажилласан жил, албан тушаалын ангилал, боловсрол, туршлага, нийгмийн хамгаалал гэсэн 4 бүлэг, нарийвчилсан 26 мэдээлэл бүхий үзүүлэлтээр гаргасан болно.


Нийслэл, дүүргийн Газрын алба

Нийслэлийн хэмжээнд нийт 210 албан хаагч ажиллаж байна. Хүйсийн харьцаагаар 54% эрэгтэй, 46% эмэгтэй ажилчид байна /Зураг 1.2.3/.




Зураг 1.2.3: Нийслэлийн хэмжээнд газрын салбарт ажиллаж байгаа албан хаагчдын хүйсийн харьцаа

Насны ангиллаар 18-30 насны 26%, 31-40 насны 42%, 41-50 насны 18%, 51-с дээш насны 14% албан хаагч ажиллаж байна /Зураг 1.2.4/.



Зураг 1.2.4: Нийслэл, дүүргийн Газрын албаны албан хаагчдын насны ангилал


Нийслэл, дүүргийн Газрын албанд 6-15 жил төрийн албанд ажиллаж байгаа албан хаагчид хамгийн их буюу 46%-ийг эзэлж байна.



Зураг 1.2.5: Нийслэл, дүүргийн Газрын албаны албан хаагчдын төрийн албанд мэргэшсэн байдал


Нийслэл, дүүргийн Газрын албан хаагчдын 176 буюу 84% нь төрийн захиргааны албан хаагч, 34 буюу 16% нь төрийн үйлчилгээний албан хаагч байна.

Төрийн захиргааны албан хаагчид ТЗ-5-аас ТЗ-10 хүртэл албан тушаалын зэрэглэлтэй байна /Зураг 1.2.6/.




Зураг 1.2.6: Албан тушаалын ангилал, зэрэглэл

Нийслэл, дүүргийн Газрын албаны 210 албан хаагчид 100% дээд боловсролтой, үүнээс 136 буюу 65% бакалавр зэрэгтэй, 74 албан хаагч буюу 35% магистр зэрэгтэй ажилчид байна /Зураг 1.2.7/.



Зураг 1.2.7: Нийслэл, дүүргийн Газрын албаны албан хаагчдын боловсролын түвшин

Газрын харилцааны ажлын байранд шаардагддаг ArcGIS, AutoCAD, Лэнд менежер программ хангамжийг нийслэл, дүүргийн Газрын албаны албан хаагчдын 100% нь дундаас дээд түвшинд эзэмшсэн байна /Зураг 1.2.8/.




Зураг 1.2.8: Нийслэлийн Газрын албаны албан хаагчдын ур чадвар

Гадаад хэлний мэдлэгээр 68 албан хаагч 2 буюу түүнээс дээш хэлний мэдлэгтэй, үүний ихэнх нь англи, орос хэлний хосолсон, нийт албан хаагчдын 52% Англи, 33% Орос хэлийг эзэмшсэн бусад буюу Солонгос, Хятад, Герман, Япон хэлийг 15% нь эзэмшсэн байна /Зураг 1.2.9/.



Зураг 1.2.9: Нийслэлийн Газрын албаны албан хаагчдын хэлний мэдлэг

Албан хаагчдын 61% нь газар эзэмших, өмчлөх, ашиглах эрхтэй байна. Нийслэл, дүүргийн Газрын албаны албан хаагчдын 68% нь банк, санхүүгийн байгууллагад зээлтэй, 32% нь зээлгүй байна /Зураг 1.2.10/.




Зураг 1.2.10: Нийслэл, дүүргийн албан хаагчдын нийгмийн асуудал

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар


21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт ажиллаж байгаа албан хаагчдыг насны байдлаар ангилж үзвэл:

Нийт албан хаагчдын 29% нь 18-30 насны, 47% нь 31-40 насны, 13% нь 41- 50 насны, 11% нь 51-ээс дээш насныхан байна /Зураг 1.2.11/.



Зураг 1.2.11: Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нийт албан хаагчдын насны харьцуулалт

Нийт албан хаагчдын 58% нь эрэгтэй, 42% нь эмэгтэй, албан хаагчдын 83% нь тухайн орон нутгийн уугуул иргэд ажиллаж байна /Зураг 1.2.12/.




Зураг 1.2.12: Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчдын хүйсийн харьцаа болон тухайн орон нутгийн уугуул иргэн эсэх

Аймгийн Газрын албанд 6-15 жил төрийн албанд ажиллаж байгаа албан хаагчид хамгийн их хувийг эзэлж байна /Зураг 1.2.13/.




Зураг 1.2.13: Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын албан хаагчдын төрийн албанд мэргэшсэн байдал, жилээр

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нийт 363 албан хаагчдаас Төрийн захиргааны албан хаагч 53%, Төрийн үйлчилгээний албан хаагч 47% байна /Зураг 1.2.14/.




Зураг 1.2.14: Албан тушаалын ангилал, төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвтэй эсэх

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын нийт албан хаагчдын 74% нь бакалаврын зэрэгтэй, 15% нь магистрын зэрэгтэй, 11% нь бүрэн болон тусгай дунд боловсролтой байна. Бүрэн болон тусгай дунд боловсролтой албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх чиглэлийн үйлчилгээний албан үүргийг гүйцэтгэж байна /Зураг 1.2.15/.




Зураг 1.2.15: Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчдын боловсролын түвшин

Ажлын байранд шаардагддаг программ хангамжийг нийт албан хаагчдын 74% нь бүрэн болон сайн эзэмшсэн, давхардсан тоогоор англи хэлний мэдлэгтэй 275, орос хэлний мэдлэгтэй 134, бусад хэл буюу Солонгос, Япон, Хятад, Герман хэлний мэдлэгтэй 11 албан хаагч ажиллаж байна /Зураг 1.2.16/.



Зураг 1.2.16: Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчдын ур чадвар

Нийт албан хаагчдын 55% нь эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн газартай, 80% нь санхүүгийн байгууллагад тодорхой хэмжээний зээлтэй байна /Зураг 1.2.17/.




Зураг 1.2.17: Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын албан хаагчдын нийгмийн асуудал

Сумдын Газрын даамлууд


21 аймгийн нийт 330 суманд 361 газрын даамал ажиллаж байгаа бөгөөд ажлын онцлогоос шалтгаалж цөөн тооны суманд 2 газрын даамал ажиллаж байна.

Сумын газрын даамлуудыг нас болон хүйсээр нь харьцуулан авч үзэхэд: нийт газрын даамлуудын 44% нь 18-30 насны, 41% нь 31-40 насны, 15% нь 41 ба түүнээс дээш насны албан хаагчид ажиллаж байна /Зураг 1.2.18/.




Зураг 1.2.18: Сумын газрын даамлуудын насны ангилал

Нийт албан хаагчдын 55% нь эрэгтэй, 45% нь эмэгтэй албан хаагчид байгаа ба 89 % нь тухайн орон нутгийн уугуул иргэд ажиллаж байна /Зураг 1.2.19/.




Зураг 1.2.19: Сумын газрын даамлуудын хүйсийн харьцаа, тухайн орон нутгийн уугуул иргэд эсэх

Газрын даамлуудын 92% нь төрийн албанд 1-ээс 15 жил ажиллаж байна. 26 албан хаагч буюу 8% нь төрийн албанд 16-аас дээш жил ажиллаж байна /Зураг 1.2.20/.




Зураг 1.2.20: Сумын Газрын даамлуудын ажилласан жил

Төрийн албан хаагчийн ангиллын зэрэглэлийн хувьд 93% нь төрийн захиргааны албан хаагчид байна /Зураг 1.2.21/.




Зураг 1.2.21: Сумын газрын даамлуудын хаагчийн ангилал зэрэглэл

Нийт ажилчдын 98% бакалаврын зэрэгтэй, 1% нь магистрын зэрэгтэй, 1% нь бүрэн болон тусгай дунд боловсролтой Газрын даамал ажиллаж байна /Зураг 1.2.22/.



Зураг 1.2.22: Сумын газрын даамлуудын боловсролын түвшин


Давхардсан тоогоор англи хэлний мэдлэгтэй 291, орос хэлний мэдлэгтэй 78, бусад хэлний мэдлэгтэй 2 газрын даамал ажиллаж байна /Зураг 1.2.23/.



Зураг 1.2.23: Сумын газрын даамлуудын хэлний түвшин

Сумдын Газрын даамлууд ажлын байранд шаардагдах програм хангамжийг тодорхой хэмжээгээр эзэмшсэн ба үүнээс 17 нь бүрэн, 256 нь сайн, 88 нь дунд хэмжээгээр эзэмшсэн байгаагаас харахад цаашид улам мэргэшүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй байна.


Нийт албан хаагчдын 51% нь эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн газартай, 79% нь санхүүгийн байгууллагад тодорхой хэмжээний зээлтэй байна /Зураг 1.2.24/.



Зураг 1.2.24: Сумын газрын даамлуудын нийгмийн асуудал


1.3. ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

2018 онд 21 аймгийн хэмжээнд Газрын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд давхардсан тоогоор нийт 834 удаагийн хяналт, шалгалт хийснээс нийт 11630 зөрчил илэрсэн байна /Зураг 1.3.1/.



Зураг 1.3.1: 2018 онд Газрын харилцааны хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалт хийгдсэн тоо болон илэрсэн зөрчлийн тоо /аймаг тус бүрээр/


Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтын тоо, хэмжээ улсын хэмжээнд 2015, 2016 онуудад жил дараалан өссөн үзүүлэлттэй байсан бол 2018 онд 2017 оныхоос буурсан үзүүлэлттэй байна /Зураг 1.3.2/.



Зураг 1.3.2: Газрын харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийсэн тоо /2015- 2018 он/

2018 онд Хөвсгөл, Баянхонгор, Булган, Дорнод, Төв, Сэлэнгэ, Төв аймгууд Газрын талаарх хууль тогтоомжид хяналт, шалгалтыг хамгийн олон удаагийн давтамжтай буюу ихэнх сумдаа хамруулж 51-150 удаа явуулсан байна /Зураг 1.3.3/.


Харин Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон зэрэг цөөн тооны сумтай аймгууд хамгийн бага давтамжтай буюу 3-5 удаа хяналт шалгалтыг явуулжээ.



Зураг 1.3.3: Газрын харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтын тоо

Орон нутагт хийсэн хяналт, шалгалтын ажлын давтамжаас хамаарч илэрсэн зөрчлийн тоо харилцан адилгүй байна.


2018 онд Газрын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтаар нийт 11630 зөрчил илэрсэн байна. Үүний 10521 буюу 91% нь газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, 962 буюу 8% нь эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй газар ашигласан зөрчил эзэлж байгаа бол 147 буюу 1% нь төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан зөрчил тус тус эзэлж байна /Зураг 1.3.4/.



Зураг 1.3.4: Газрын харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийн төрөл, түүний харьцуулалт

2018 онд эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр газар ашигласан, төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан зөрчил өмнөх онуудаас буурсан үзүүлэлттэй, харин газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчил өссөн үзүүлэлттэй байна.

Газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчлийг дотор нь ангилж авч үзвэл 2 жил дараалан ашиглаагүй 3606 /34%/, гэрээнд заасан зориулалт бусаар газар ашигласан 312 /3%/, газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа дууссан 903 /9%/, газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй 5700 /54%/ зөрчил тус тус эзэлж байна /Зураг 1.3.5/.




Зураг 1.3.5: Газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх зөрчил

Зураг 1.3.5-аас харахад газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа дууссан зөрчил 70%-иар, гэрээнд заасан зориулалт бусаар газар ашигласан зөрчил өмнөх оныхоос 11%-иар, газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй зөрчил 20%-иар, 2 жил дараалан ашиглаагүй зөрчил 19%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

1.4. ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТ, ТЭДГЭЭРИЙН БАРАГДУУЛАЛТЫН СУДАЛГАА


2018 онд 21 аймаг болон нийслэлийн хэмжээнд газар ашиглах, эзэмших, эзэмшиж байгаа газраа өмчлөх, шинээр өмчлөх эрхтэй холбогдон ирүүлсэн өргөдөл хүсэлтийн судалгааг нэгтгэн дүгнэхэд нийт 298343 өргөдөл, хүсэлт ирүүлснээс шинээр газар эзэмших 31071 /10.4%/, шинээр газар ашиглах 1257 /0.4%/, газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх 12921 /4.3%/, газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалах 9788 /3.2%/, газар ашиглалтын зориулалт өөрчлөх 2177 /0.7%/, газар эзэмших, ашиглах гэрээ, гэрчилгээний хугацаа сунгуулах 9386 /3.1%/, эзэмшил газраа бусдад ашиглуулах 84 /0.02%/, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нөхөн авах 1539 /0.5%/, эзэмшиж байгаа газраа өмчлөх 13190 /4.4%/, өмчилсөн газрынхаа хэмжээг өөрчлөх 4889 /1.6%/, өмчилсөн газраа барьцаалах 96201 /32.2%/, шинээр газар өмчлөх 51537 /17.2%/, өмчлөх эрхээ шилжүүлэх 63438 /21.2%/, газар эзэмших, ашиглах эрхээ хүчингүй болгуулах хүсэлт 865 /0.28% / тус тус өргөдөл хүсэлт ирүүлсэн байна.

Тайлант онд 21 аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 298343 өргөдөл, хүсэлт ирснээс 263541 /88.3% / өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэсэн байна. Нийт өргөдөл, хүсэлтээс 34802 /11.7% / өргөдөл, хүсэлт шийдвэрлэгдээгүй байна.



Зураг 1.4.1: Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлтийн байдлын судалгаа

2017 оны тайлангийн дүнтэй харьцуулахад шинээр газар эзэмших өргөдөл 9401, газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалах өргөдөл 3925, эзэмшил газраа бусдад ашиглуулах өргөдөл 21, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг нөхөн авах өргөдөл 3024, шинээр газар өмчлөх өргөдөл 1619-өөр тус тус буурч, шинээр газар ашиглах өргөдөл 630, газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх 263, газар ашиглалтын зориулалт өөрчлөх 674, газар эзэмших, ашиглах гэрээ, гэрчилгээний хугацаа сунгах 4655, эзэмшиж байгаа газраа өмчлөх 5149, өмчилсөн газрынхаа хэмжээг өөрчлөх 2309, өмчилсөн газраа барьцаалах 79999, өмчлөх эрхээ шилжүүлэх 59615, хүчингүй болгуулах хүсэлт 401-ээр нэмэгдсэн байна.



Зураг 1.4.2: Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлтийн байдлын судалгааг 2017 оной харьцуулсан байдал

Өргөдөл, хүсэлт дараах шалтгааны улмаас шийдвэрлэгдээгүй байна. Үүнд:

- Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт хүсэлт гаргасан;
- Өргөдөл, хүсэлтийн баримт бүрдүүлэлт дутуу;
- Хүсэлт ирүүлсэн газар бусдад олгогдсон, давхардсан;
- Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явагдсанаас хойш материалаа ирүүлсэн;
- Бичиг баримтын зөрчилтэй, баримт бичгийн бүрдүүлэлт дутуу, инженерийн шугам сүлжээ бүхий газар, авто замын зурвас газарт орсон;
- Нисэхийн хориотой бүсэд, үерийн аман дээр газар ашиглах, эзэмших, өмчлөх, зөвшөөрөлгүй газар дээр газар ашиглах;
- Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан газрыг авахаас татгалзсан;
- Суурин судалгааны явцад шийдвэрлэгдэх боломжгүй нь тодорхойлогдсон.

1.5. ГАЗРЫН МАРГААН, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Улсын хэмжээнд 2018 онд газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхтэй холбогдон гарсан маргааны судалгааг нэгтгэн дүгнэхэд нийт 5458 маргаан гарснаас газар эзэмшихтэй холбоотой 1175, газар өмчлөхтэй холбоотой 737, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэстэй холбоотой 3437, газар ашиглахтай холбоотой 109 маргаан тус тус гарсан байна.


Хүснэгт 1.5.1: Газрын маргаан, түүнийг шийдвэрлэсэн байдал /аймаг, нийслэлээр/

№	Аймгийн нэр	Маргааны тоо				Үүнээс							
						Шийдвэрлэгдсэн				Шийдвэрлэгдээгүй			
		Эзэмших	Өмчлөх	Хилийн цэстэй холбоотой	Ашиглах	Эзэмших	Өмчлөх	Хилийн цэстэй холбоотой	Ашиглах	Эзэмших	Өмчлөх	Хилийн цэстэй холбоотой	Ашиглах
1	Архангай	23	0	8	0	16	0	7	0	7	0	1	0
2	Баянхонгор	144	15	56	15	84	13	29	9	54	3	31	8
3	Баян-Өлгий	103	38	8	20	85	32	7	17	18	6	1	3
4	Булган	46	425	8	8	31	33	1	8	3	280	7	0
5	Говь-Алтай	78	3	62	0	59	2	36	0	19	1	26	0
6	Говьсүмбэр	1											
7	Дархан-Уул	33	20	0	0	32	12	0	0	1	3	0	0
8	Дорнод	17	5	1	0	16	5	1	0	0	0	0	0
9	Дорноговь	115	2	39	1	14	0	33	0	101	2	6	1
10	Дундговь	15	17	31	0	22	3	14	0	5	2	33	0
11	Завхан	29	0	6	0	5	0	5	0	24	0	1	0
12	Орхон	33	20	0	0	32	12	0	0	1	3	0	0
13	Өвөрхангай	25	3	13	0	9	3	11	0	16	0	2	0
14	Өмнөговь	14	14	16	0	10	11	4	0	3	3	12	0
15	Сүхбаатар	2	14	2	0	2	10	1	0	0	4	1	0
16	Сэлэнгэ	12	16	8	18	8	13	4	18	2	4	1	9
17	Төв	125	66	3140	3	113	66	48	3	3	1	2580	0
18	Увс	29	2	7	0	26	2	4	0	3	3	0	0
19	Ховд	105	15	0	42	86	10	0	1	20	5	0	42
20	Хөвсгөл	100	7	9	0	91	4	4	0	9	5	3	0
21	Хэнтий	20	10	20	0	14	9	15	0	6	1	5	0
22	Улаанбаатар	106	45	3	2	57	21	0	0	49	24	3	2
Дүн		1175	737	3437	109	812	261	224	56	344	350	2713	35

Улсын хэмжээнд нийт 5458 маргаан гарснаас 1353 газрын маргааныг шийдвэрлэсэн байна.


Газрын маргаан дараах шалтгааны улмаас шийдвэрлэгдэхгүй байна. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгийн холбоотой маргаан тул шүүхээр шийдвэрлэгдэх шатандаа байгаа;
- Мэргэжлийн хяналтын байгууллагын шалгалтын дүгнэлт хүлээгдэж байгаа.



Зураг 1.5.1: Газрын маргааныг шийдвэрлэсэн байдал

2018 онд гарсан маргааны тоог 2017 онд гарсан маргааны тоотой харьцуулахад газар эзэмших талаар гарсан маргаан 315, хилийн цэстэй холбоотой маргаан 1214-аар тус тус багассан, өмчлөх талаарх маргаан 490, газар ашиглалттай холбоотой маргаан 77-оор ихэссэн дүнтэй байна /Зураг 1.5.2/.



Зураг 1.5.2: Газрын маргааны тоог өнгөрсөн онтой харьцуулсан байдал

1.6. ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ БОЛОН ӨМЧИЙН ГАЗРАА БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАРЬЦААЛСАН БАЙДЛЫН ТАЙЛАН

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1. дэх хэсэгт “Газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр бусдад шилжүүлж, барьцаалж болно. Эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, барьцаалах үйл ажиллагаа нь зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд явагдана” гэж заасан байдаг ба газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газрын улсын бүртгэлд бүртгүүлэхээр хуульчилсан билээ. Мөн “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.8-д эрхийн гэрчилгээ барьцаалах болон эзэмшил газраа бусдад ашиглуулах хүсэлтийг тухайн шатны Засаг дарга зөвшөөрсөн тохиолдолд энэ тухай албан бичгийг үндэслэн газрын кадастрын мэдээллийн сантай бол мэдээллийн санд, байхгүй бол энэ журмын 5 дугаар хавсралт “Газар ашиглуулсан, барьцаалсан тухай бүртгэл”-д бүртгэж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ гэж заасан байдаг.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамж болон Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ээр барьцаа бүртгэлийг хийж байгаа бөгөөд 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын Газрын даамал барьцаалсан бүртгэлийг бүртгэж жилийн эцсээр нэгтгэн тайлан гаргаж байна.


Тухайн бүртгэлээс харахад 2018 онд Улсын хэмжээнд 11621 газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байна. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан судалгаагаар 88911 улсын иргэн өөрийн өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан ба нийт 50393 нэгж талбар /газар эзэмших эрх, өмчийн газар/ буюу Монгол улсын нийт нэгж талбарын 8.08 хувь нь барьцаанд байна. Энэ нь өмнөх онуудаас ойролцоогоор 2 хувиар өссөн дүнтэй гарсан бөгөөд газрын үр өгөөж нэмэгдэж, эдийн засгийн эргэлтэнд орж байгаагийн том илрэл болж байна.

2018 онд газар эзэмших эрх болон өмчийн газраа барьцаалсан байдлыг Улсын хэмжээнд нэгтгэж хүснэгт 1.6.1, зураг 1.6.1-д үзүүлэв.

Хүснэгт 1.6.1: Газар эзэмших эрх болон өмчийн газраа шинээр барьцаалсан байдал


№	Аймаг, нийслэл	Барьцаалсан нэгж талбарын тоо	Үүнээс	
			Эзэмших	Өмчлөх
1	Архангай	2030	178	1852
2	Баян-Өлгий	1894	317	1577
3	Баянхонгор	3606	269	3337
4	Булган	1183	152	1031
5	Говь-Алтай	1318	575	743
6	Говьсүмбэр	1707	85	1622
7	Дархан-Уул	4553	328	4225
8	Дорнод	1144	87	1057
9	Дорноговь	1085	405	680
10	Дундговь	2061	129	1932
11	Завхан	1498	91	1407
12	Орхон	5354	179	5175
13	Өвөрхангай	4909	365	4544
14	Өмнөговь	3308	60	3248

15	Увс	3353	458	2895
16	Сүхбаатар	1873	119	1754
17	Сэлэнгэ	4314	704	3610
18	Төв	2486	72	2414
19	Ховд	3218	356	2862
20	Хөвсгөл	2330	285	2045
21	Хэнтий	2075	76	1999
22	Нийслэл	45233	6331	38902
ДҮН		100532	11621	88911



Зураг 1.6.1: Өмнөх оны мэдээтэй харьцуулсан байдал

Тайлант онд бүртгүүлсэн газар эзэмших эрхээ болон өмчийн газраа барьцаалсан байдлаас харахад нийт барьцаанд байгаа газрын 44 хувь нь гэр бүлийн хэрэгцээний газар байна. Улсын хэмжээнд хөдөө аж ахуйн зориулалттай буюу төмс, хүнсний ногоо тариалан, жимс, жимсгэний усалгаагүй тариалан, үр тарианы усалгаагүй тариалан, өвөлжөө, хаваржааны гэх мэт газрын банк, санхүүгийн байгууллагуудад барьцаалсныг зураг 1.6.2-д үзүүлэв.




Зураг 1.6.2: Барьцаалсан газар эзэмших эрх болон өмчийн газрын төрөл

2018 онд улсын хэмжээнд 11621 эзэмших эрхийг банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан ба дээрх бүртгэлийг улсын хэмжээнд нэгтгэн сүүлийн 5 жилийн мэдээтэй харьцуулав /Хүснэгт 1.6.2, Зураг 1.6.3/.

Хүснэгт 1.6.2: 2018 онд улсын хэмжээнд шинээр эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдал


д/д	Аймаг, нийслэл	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
1	Архангай	298	104	122	153	178
2	Баян-Өлгий	533	934	31	107	317
3	Баянхонгор	1040	707	433	524	269
4	Булган	231	168	131	160	152
5	Говь-Алтай	386	605	449	561	575
6	Говьсүмбэр	61	65	103	151	85
7	Дархан-Уул	1283	423	189	409	328
8	Дорнод	102	63	297	74	87
9	Дорноговь	352	93	35	365	405
10	Дундговь	57	50	73	161	129
11	Завхан	114	358	0	391	91
12	Орхон	136	42	744	130	179
13	Өвөрхангай	317	323	127	313	365
14	Өмнөговь	185	313	58	91	60
15	Увс	970	966	130	859	458
16	Сүхбаатар	488	156	156	82	119
17	Сэлэнгэ	882	1226	8	361	704
18	Төв	524	295	199	67	72
19	Ховд	393	449	392	380	356
20	Хөвсгөл	615	499	343	320	285
21	Хэнтий	156	141	56	173	76
22	Нийслэл	913	828	4521	5152	6331
Нийт		10036	8808	8597	10984	11621



Зураг 1.6.3: Өмнөх оны мэдээтэй харьцуулсан байдал

2018 онд газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан бүртгэлийг өмнөх онтой харьцуулахад 1.05 хувиар өсч 11621 болсон байна.

2018 онд газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдлаас харахад 84 хувийг банкинд, үлдсэн 16 хувийг банк бус санхүүгийн байгууллага, хоршоо болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад барьцаалсан байна. Үүнээс хамгийн их хувь буюу 39 хувийг Хаан банкинд, 14 хувийг Хас банкинд, 11 хувийг Төрийн банкинд, 5 хувийг Голомт банкинд барьцаалсан байна /Зураг 1.6.4/.



Зураг 1.6.4: Газар эзэмших эрхийг банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдал.

Газар эзэмших эрх болон өмчийн газрыг банк, санхүүгийн байгууллагад барьцаалан хувьд дунджаар 1.32 жил байна.

1.7. ГАЗРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Газар, газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнэ ханш, эрэлт хэрэгцээ, ханган нийлүүлэлтийг жигд тогтвортой байлгах, энэ талаарх мэдээллээр олон нийтэд үйлчилгээ үзүүлэх, мэдээллийг нээлттэй ил тод болгох, газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, татвар, төлбөр авах замаар Монгол улсын эдийн засгийн хөгжилд бодитой дэмжлэг үзүүлэхэд газрын зах зээлийн асуудлууд чухал юм. Мөн үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх нь инфляцийн эсрэг сайн хамгаалалт болдог тул хөрөнгө оруулагчид энэ төрлийн хөрөнгө оруулалтыг сонирхдог бөгөөд газар болон үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн талаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажилуудыг судлан зах зээлийн бүтэц, оролцогч талуудын оролцоо, үл хөрөнгийн үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлүүдийг судалж дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай байдаг.

Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг бүрдүүлж, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан байгуулах үүднээс Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд тус системийг ашиглан нийслэлийн Газрын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, дүүргүүдийн Газрын алба, сумдын Газрын даамлууд газрын зах зээлийн үнийн мэдээг цуглуулан ажиллаж байна.

Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар /хуучин нэрээр/-ын даргын 2011 оны 182 тоот тушаалаар “Газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулах заавар, маяг”-ын дагуу гэр бүлийн хэрэгцээний зориулалттай /ГХ/, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай /ХАА/, худалдаа үйлчилгээний зориулалттай /ХҮ/, хөдөө аж ахуйн газраас бусад үйлдвэрлэлийн зориулалттай /Ү/ гэсэн 4 төрлөөр цуглуулж байна. Мөн газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг газрын эрхээ шилжүүлж байгаа худалдагчаас, шилжүүлж авч байгаа худалдан авагчаас, түрээслэгч, түрээслүүлэгч болон бусад эх сурвалжаас бүрдүүлж байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар Газрын биржийн цахим системд нийт 16056 газрын газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээ бүртгэгдээд байгаа бөгөөд үүнээс тайлант онд 2892 газрын зах зээлийн үнийн мэдээ бүртгэгдсэнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 2036, худалдаа үйлчилгээний зориулалттай 418, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай 180, хөдөө аж ахуйн газраас бусад үйлдвэрлэлийн зориулалттай 258 үнийн мэдээ тус тус бүрдүүлсэн байна.

Хүснэгт 1.7.1: Газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулсан байдал


№	Аймаг/нийслэл	Нийт үнийн мэдээ	Үүнээс							
			Гэр бүлийн хэрэгцээний газар	Үүнээс		Худалдаа үйлчилгээний газар	Үүнээс		Хөдөө аж ахуйн газар	Үйлдвэрийн газар
				Ул хөдлөх хөрөнгөтэй	Ул хөдлөх хөрөнгөгүй		Ул хөдлөх хөрөнгөтэй	Ул хөдлөх хөрөнгөгүй		
1	Нийслэл	331	209	68	141	44	36	8	0	78
2	Архангай	151	87	50	37	20	6	14	22	22
3	Баян-Өлгий	103	82	33	49	9	9	0	6	6
4	Баянхонгор	254	235	50	185	17	5	12	1	1
5	Булган	110	67	40	27	21	5	16	11	11
6	Говь-Алтай	26	19	2	17	5	5	0	1	1
7	Говьсүмбэр	34	28	2	26	2	1	1	2	2
8	Дархан-Уул	136	120	71	49	12	6	6	2	2
9	Дорноговь	152	88	12	76	46	13	33	9	9
10	Дорнод	135	83	19	64	12	1	11	20	20
11	Дундговь	166	139	31	108	19	14	5	4	4
12	Завхан	35	31	19	12	4	3	1	0	0
13	Орхон	158	149	38	111	9	4	5	0	0
14	Өвөрхангай	199	138	53	85	39	11	28	11	11
15	Өмнөговь	176	163	22	141	13	1	12	0	0
16	Сэлэнгэ	139	65	29	36	14	5	9	30	30
17	Сүхбаатар	137	123	59	64	14	4	10	0	0
18	Төв	56	16	5	11	12	1	11	14	14
19	Увс	62	22	9	13	20	2	18	10	10
20	Ховд	17	5	2	3	4	2	2	4	4
21	Хэнтий	139	60	16	44	47	13	34	16	16
22	Хөвсгөл	176	107	19	88	35	25	10	17	17
Нийт дүн		2892	2036	649	1387	418	172	246	180	258

Зах зээлийн үнийн мэдээний 70 хувийг гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын үнэ, 15 хувийг худалдаа үйлчилгээний зориулалттай газрын үнэ, 6 хувийг хөдөө аж ахуйн зориулалттай газрын үнэ, 9 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай газрын үнийн мэдээ эзэлж байгаа юм.




Зураг 1.7.1: Газрын зах зээлийн үнийн мэдээний эзлэх хувь.

Нийт цуглуулсан үнийн мэдээний хувьд 1866 буюу 73 хувь нь шууд худалдагдсан үнэ байна. Мөн дуудлага худалдаагаар худалдагдсан үнийн мэдээ нийт үнийн мэдээний 18 хувийг, үнэлэгдсэн болон худалдахаар санал болгож буй үнэ үлдсэн 9 хувийг нь эзэлж байна.



Зураг 1.7.2: Газрын зах зээлийн үнийн мэдээний төрөл.

Үнийн мэдээний эх сурвалжийн хувьд газрын эрхээ шилжүүлж байгаа худалдагчаас 48 хувийг, шилжүүлж авч байгаа худалдан авагчаас 44 хувийг, түрээслэгч, түрээсүүлэгч болон бусад эх сурвалжаас 8 үнийн мэдээг бүрдүүлсэн байна.




Зураг 1.7.3: Газрын зах зээлийн үнийн мэдээний эх сурвалж, эрхийн төрөл

Мөн нийт цуглуулсан үнийн мэдээг эрхийн төрлөөр нь ангилахад 1346 өмчилсөн газрын, 1418 эзэмшил газрын, 128 ашиглалтад байгаа газрын үнийн мэдээ тус тус бүртгэгдсэн байна.

Гэр бүлийн хэрэгцээний газар

Газрын биржийн цахим системд 2892 гэр бүлийн хэрэгцээний газрын үнийн мэдээ бүртгэгдсэн бөгөөд уг мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд газрын үнэ нь байршил, орон нутгийн эдийн засаг, нийгмийн байдлаас хамаарч харилцан адилгүй байгаа тул газрын үнийг улсын хэмжээнд дундажлах боломжгүй байна. Иймд аймаг тус бүрээр нь газрын дундаж үнийг тооцож гаргасан.




Зураг 1.7.4: Гэр бүлийн хэрэгцээний 1 метр квадрат газрын дундаж үнэ

Тайлант хугацаанд гэр бүлийн хэрэгцээний газрын дундаж үнэ нийслэл Улаанбаатар хотод хамгийн өндөр бөгөөд байршлаасаа хамаарч харилцан адилгүй байна. Нийслэл Улаанбаатар хотын гэр бүлийн хэрэгцээний 209 газрын үнийн мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд хөрөнгө оруулалт хийгдээгүй 1 метр квадрат газрын дундаж үнэ 17000 төгрөг, хөрөнгө оруулалт хийгдсэн 1 метр квадрат газрын дундаж үнэ 35000 төгрөг байна. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотод нэг айлын 0,07 га газрын дундаж үнэ хөрөнгө оруулалт хийгдээгүй бол 11,900,000 төгрөг, хөрөнгө оруулалт хийгдсэн бол 24,500,000 төгрөгөөр эдийн засгийн эргэлтэнд орж байна.

Мөн аймгуудын хувьд хөрөнгө оруулалт хийгдсэн гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ Өмнөговь, Дархан, Орхон, Архангай, Сэлэнгэ, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь аймагт 20,000-25,000 төгрөг, Дорноговь, Сүхбаатар, Булган, Ховд, Завхан аймагт 10,000-19,000 төгрөг, бусад аймагт 5,000-9,999 төгрөг байна.

Худалдаа үйлчилгээний зориулалттай газар

Улсын хэмжээнд худалдаа үйлчилгээний зориулалттай газрын зах зээлийн үнийн 418 мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна.




Зураг 1.7.5: Худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ

Худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ Улаанбаатар хотын хувьд 59478 төгрөг, Дархан-Уул, Хөвсгөл, Дундговь, Ховд, Завхан, Орхон, Сэлэнгэ аймагт 20,000-42,000 төгрөг, Хэнтий, Увс, Говь-Алтай, Өвөрхангай, Баян-Өлгий аймагт 15,000-19,900 төгрөг бусад аймагт 10,000-14,999 төгрөгийн хооронд байна.

ХАА-н зориулалттай газар

Улсын хэмжээнд хөдөө аж ахуйн зориулалттай /Төмс, хүнсний ногоо тариалан, Жимс, жимсгэний усалгаагүй тариалан, Үр тарианы усалгаагүй тариалан, Өвөлжөө, хаваржааны гэх мэт/ газрын зах зээлийн үнийн 180 мэдээ цуглуулаад байна.




Зураг 1.7.6: Хөдөө аж ахуйн 1 метр квадрат газрын дундаж үнэ

Хөдөө аж ахуйн зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 5821 төгрөг, Ховд аймагт 1254 төгрөг, бусад аймагт 169-898 төгрөгийн хооронд байна.

Үйлдвэрийн газар

Тайлант онд Улсын хэмжээнд үйлдвэрийн зориулалттай газрын зах зээлийн үнийн 26 мэдээ цуглуулсан үүнээс хамгийн өндөр буюу Улаанбаатар хотын үйлдвэрийн зориулалттай 1 метр квадрат газрын дундаж 24063 төгрөг байна. Харин бусад аймгуудын хувь 1000-4000 төгрөгийн хооронд байна.




Зураг 1.7.7: Үйлдвэр үйлчилгээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ.

2018 оны байдлаар улсын хэмжээнд нийт 1243652 газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч бүртгэгдсэн ба үүнээс 93869 нь буюу 7.54 хувь нь газрын зах зээлийн эргэлтэнд орсон байна.

Хүснэгт 1.7.2: Газар өмчлөгч, эзэмшигчийн эрхийн өөрчлөлт

Он	Газар эзэмших эрхийн өөрчлөлт	Үүнээс		Газар өмчлөх эрхийн өөрчлөлт	Үүнээс		
		Газар эзэмших эрхээ шилжүүлсэн	Газар эзэмших эрхээ барьцаалсан		Газар өмчлөх эрхээ худалдсан	Газар өмчлөх эрхээ бэлэглэсэн	Газар өмчлөх эрхээ барьцаалсан
2014 он	14742	5521	9221	44025	8341	4982	30702
2015 он	14684	5876	8808	41521	7011	4406	30104
2016 он	23949	10848	13101	42105	7284	3525	31296
2017 он	24344	10984	13360	52402	9117	3876	39409
2018 он	23855	11964	11621	104954	12036	4007	88911



Зураг 1.7.8: Газар өмчлөгч, эзэмшигчийн эрхийн өөрчлөлт

2018 онд 93869 га газар буюу ойролцоогоор нийт газар нутгийн 0.06 хувь нь эдийн засгийн эргэлтэнд орсон байна. Харин газар өмчлөх, эзэмших эрхийн санхүүгийн эргэлтийн хэмжээ 914.67 тэрбум төгрөг болж, 25 хувиар нэмэгдсэн судалгаа гарсан байна.

Тухайн тайлант онд Үндэсний статистикийн хорооны гаргасан судалгаагаар Монгол улсын ДНБ 23.5 их наяд төгрөгт ба үүнээс газрын зах зээлийн санхүүгийн эргэлтийн хэмжээ ДНБ-ий 3.89%-ийг эзэлж, газрын зах зээлийн санхүүгийн эргэлтийн эзлэх хувь нэмэгдэж газрын үр өгөөж өсч байна.

1.8. ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА ХУДАЛДАА, ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭ, ТАЙЛАН

2018 онд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа, газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг дараах тогтоол, журам аргачлалуудын дагуу улсын хэмжээнд зохион байгуулан ажиллав. Үүнд:

- Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”;
- Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”;
- Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 182 дугаар тогтоол;
- Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 208 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”.

1.8.1. Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа

2018 онд улсын хэмжээнд 1179 удаа газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулснаас 711 дуудлага худалдаа хүчинтэй болж, 7698.85 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлжээ. Энэ нь өмнөх оныхтой харьцуулж үзвэл газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан тоо 2 дахин, эзэмшүүлсэн газрын хэмжээ 308.43 га-гаар тус тус нэмэгдсэн байна /Хүснэгт 1.8.1.1/.

Хүснэгт 1.8.1.1: 2018 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан байдал


№	Аймаг, нийслэл	Дуудлага худалдаа зохион байгуулсан тоо		Талбай /м2/		Төсөвт орсон орлого /мян.төг/	
		2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
1	Архангай	60	84	10392979	17155197	171281.9	288814.2
2	Баян-Өлгий	3	4	13164	12000	75014.0	30700.0
3	Баянхонгор	14	54	30617	49624	28991.4	281279.1
4	Булган	45	40	129815	400469	70253.1	51141.9
5	Говь-Алтай		24		19822		35051.1
6	Говьсүмбэр	11	17	48236	758500	49068.8	318175.9
7	Дархан-Уул	29	41	205146	210800	406800.0	15816.4
8	Дорноговь	96	169	3835300	1654738	1202510.1	2985038.9
9	Дорнод	36	53	40245701	4855692	556710.3	461605.6
10	Дундговь	5	13	4900	14100		2662.0
11	Завхан	2	10	1400	34095	244.0	2044.6

12	Орхон	25	8	41695	60174	420320.0	114500.0
13	Өвөрхангай	12	81	22000	843000	39070.0	480009.0
14	Өмнөговь	10	34	181400	187300	67760.0	449446.0
15	Увс	16	33	9800	43200	35444.0	84054.0
16	Сүхбаатар	5	18	40000	41690	14640.0	73836.0
17	Сэлэнгэ	11	53	17796	217037	43172.7	136628.8
18	Төв	24	225	1988500	35397883	212101.4	938694.4
19	Ховд	6	9	4500	39240	5856.0	21607.0
20	Хөвсгөл	46	49	231525	3792000	93953.8	152255.7
21	Хэнтий	91	125	20967600	10965000	45898.1	422900.5
22	Нийслэл	36	35	1660670	236900	765606.8	1148620.8
ДҮН		583	1179	80072744	76988461	4304696.4	8494881.7

2018 онд Архангай, Баянхонгор, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймгууд хамгийн олон буюу 50-иас дээш газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, Баян-Өлгий, Завхан, Орхон, Ховд аймгууд хамгийн бага буюу 10-аас доош газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулсан байна.

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулсан байдлыг сум тус бүрээр авч үзвэл Архангай, Булган, Дорноговь, Дорнод, Говьсүмбэр, Дархан-Уул, Төв, Хэнтий аймгийн бүх сумд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг тогтмол зохион байгуулж байгаа бөгөөд Төв аймгийн Сэргэлэн сум хамгийн олон буюу 73 дуудлага худалдаа зохион байгуулсан бол Баянхонгор аймгийн Жаргалант сум, Дархан-Уул аймгийн Дархан сум, Дорноговь аймгийн Сайншанд, Даланжаргалан, Замын-Үүд сум, Өвөрхангай аймгийн Арвайхээр сум, Төв аймгийн Зуунмод, Алтанбулаг сум, Хэнтий аймгийн Дадал сумд 20-оос дээш газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулжээ.

2017 он, 2018 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа явуулсан тоог аймаг, нийслэлээр харьцуулан дараах зурагт үзүүлэв. /Зураг 1.8.1.1/.




Зураг 1.8.1.1: 2017 он, 2018 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа явуулсан тоо

2018 онд нийт 1179 удаагийн дуудлага худалдааг зохион байгуулснаас 444 удаагийн буюу 37.7 хувь нь хүчингүй болсон ба үүнээс 370 удаагийн буюу 83.3 хувь


нь оролцогчгүйн улмаас хүчингүй болж, 74 удаагийн буюу нийт зохион байгуулсан дуудлага худалдааны 16.7 хувь нь дуудлага худалдааны үнийг “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д заасан хугацаанд төлөөгүй байна.

Мөн дуудлага худалдаанд 1 оролцогч оролцсон тохиолдол 7.6 хувь болж 4.0 хувиар нэмэгдсэн, 2 оролцогч оролцсон тохиолдол 35.0 хувь болж 7 хувиар буурсан, 2-оос дээш оролцогч оролцсон тохиолдол 23 хувь болж 3 хувиар нэмэгдсэн байна /Зураг 1.8.1.2/.



Зураг 1.8.1.2: Дуудлага худалдааны оролцогчийн эзлэх хувь


Шинэчлэн батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д цахим хэлбэрээр дуудлага худалдааг зохион байгуулахаар журамласны дагуу 2017 онд Архангай, Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Хөвсгөл зэрэг 12 аймаг дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулж байсан бол 2018 онд 19 аймаг, нийслэл дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна /Зураг 1.8.1.3/



Зураг 1.8.1.3: 2018 онд цахим хэлбэрээр зохион байгуулсан дуудлага худалдаа

2018 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын хэмжээнд нийт 8 тэрбум 494 сая 882 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс Дорноговь аймгаас 35.1 хувь буюу 2 тэрбум 985 сая төгрөг, нийслэлээс 13.5 хувь буюу 1 тэрбум

149 сая төгрөг, Төв аймгаас 11.1 хувь буюу 939 сая төгрөгийг тус тус төвлөрүүлснээр тэргүүлж байна /Зураг 1.8.1.4/.



Зураг 1.8.1.4: 2017-2018 онд улсын хэмжээнд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын төсөвт орсон орлого /мян.төг/

2017 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааны орлогоос орон нутгийн төсөвт 4.3 тэрбум төгрөг төвлөрүүлж байсан бол уг дүн 2018 онд 2 дахин нэмэгдэж, 8.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2017 онд дуудлага худалдааны ялагчийн 71.6 хувь нь иргэн, 28.4 хувь нь аж ахуйн нэгж байсан бол 2018 онд 72.1 хувь нь иргэн, 27.9 хувь нь аж ахуйн нэгж байна.

1.8.2. Газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалт

2018 онд улсын хэмжээнд 49 удаа газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулснаас 23 хүчинтэй болж 360.3 га газрыг эзэмшүүлжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулж үзвэл газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан тоо 6 дахин, эзэмшүүлсэн газрын хэмжээ 3113.37 га-гаар тус тус буурсан байна /Хүснэгт 1.8.2.1/.


Хүснэгт 1.8.2.1: 2018 оны газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын мэдээ

№	Аймаг, нийслэл	Төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоо		Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлсэн газрын талбайн хэмжээ /м2/	
		2017 он	2018 он	2017 он	2018 он
1	Архангай	20	3	161938	211500
2	Баян-Өлгий	1		216	
3	Баянхонгор	16	4	10746653	20971
4	Булган	4	4	195000	911400
5	Говь-Алтай	3	11	473	52593
6	Говьсүмбэр	13	2	3836500	550000
7	Дархан-Уул	59		2025505	
8	Дорноговь	16	1	2448800	427700
9	Дорнод	1		300000	
10	Дундговь	3		20900	
11	Завхан	1	1	1400	1400
12	Орхон	3		20305	

13	Өвөрхангай	22		1677345	
14	Өмнөговь	18		217400	
15	Увс	2	10	3200	261900
16	Сүхбаатар				
17	Сэлэнгэ	3		10500	
18	Төв	44	3	7450000	6200
19	Ховд	8	1	150000	1750
20	Хөвсгөл	3		21200	
21	Хэнтий	64	8	5449823	1008000
22	Нийслэл		1		150000
ДҮН		304	49	34737158	3603414


Улсын хэмжээнд Говь-Алтай, Увс, Хэнтий аймгууд хамгийн олон буюу 8-аас дээш газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан бол Баян-Өлгий, Дархан-Уул, Дундговь, Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл аймгууд газар эзэмшүүлэх, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй байна.

2017 он, 2018 онд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоог аймаг, нийслэлээр харьцуулж харуулав. /Зураг 1.8.2.1/.



Зураг 1.8.2.1: 2017-2018 онд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоо

2018 онд 49 газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулснаас 22 удаагийн буюу 44.9 хувь нь төсөл ирээгүйн улмаас хүчингүй болжээ /Зураг 1.8.2.3/.



Зураг 1.8.2.3: Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын оролцогчийн эзлэх хувь

Төсөл сонгон шалгаруулалтын ялагчийн 87.5 хувь нь аж ахуйн нэгж бол үлдсэн 12.5 хувь нь иргэн байна.


2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Газрын тухай хуулийн 33.5.-д “Энэ хуулийн 33.1.2-т заасны дагуу төсөл шалгаруулах хэлбэрээр газар эзэмших эрхийг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эсхүл гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт зориулж олгоно” гэж нэмэлт өөрчлөлт орсон. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2018 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн тул тайлант онд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт өмнөх оныхоос буурсан байна.

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлсэн хугацааны хувьд авч үзвэл ихэвчлэн 15 жилээр эзэмшүүлсэн байна.

1.9. ГАЗРЫН КАДАСТРЫН СУДАЛГАА, ХЭМЖИЛ, ЗУРАГЛАЛ

Улсын хэмжээнд Газрын кадастрын мэдээллийн санд 2017 онд 645558 нэгж талбар улсын бүртгэлд бүртгэгдсэн ба 2018 оны сүүлийн байдлаар 713864 нэгж талбар болж, 68306 нэгж талбараар нэмэгдсэн байна.

Тайлант онд 3883 нэгж талбарыг хувааж, 981 нэгж талбарыг нэгтгэж, 3237 нэгж талбарын талбайн хэмжээ өөрчлөгдөж, 95291 нэгж талбар болон 14627 барилга нэмэгдэж Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн байна.




Зураг 1.9.3: Тайлант онд Газрын кадастрын мэдээллийн санд өөрчлөлт орсон байдал

Хүснэгт 1.9.1.Өмнөх оны өөрчлөлттэй харьцуулсан байдал

Д/д	Кадастрын зургийн өөрчлөлт	2017	2018	Зөрүү
1	Кадастрын зурагт орсон хуучин байсан нэгж талбар	645558	763057	117499
2	Шинээр нэмэгдсэн нэгж талбар	49992	95291	45299
3	Шинээр орсон барилга	13488	14627	1139
4	Нийт барилга	390900	440708	49808
5	Нийт цэгийн тоо	8048	9051	1003
6	Өмнөх онд бүртгэгдсэн цэг, тэмдэгтийн тоо	8362	9169	807
7	Утсан цэгийн тоо	542	118	424

2018 онд 17190 нэгж талбарын газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн мэдээлэл өөрчлөгдөн бүртгэгдэж, эрхийн шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна.

Үүнээс газар өмчлөх эрхийн шилжсэн 7096 нэгж талбар, газар эзэмших эрх шилжсэн 10079 нэгж талбар, газар ашиглах эрх шилжсэн 15 нэгж талбар байна.



Зураг 1.9.4: Газрын эрхийн шилжилт хийгдсэн нэгж талбарын тоо

1.10. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН 2018 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ


1.10.1. Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилт

Хот, тосгон, бусад суурин газрын төлөвлөгөөний хэрэгжилт:


Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөгөөр хот, тосгон бусад суурины ангиллын газарт нийт 73640 байршил бүхий 276822.82 га газрыг төлөвлөснөөс 52428 байршилд 248787.99 га газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 1.10.1.1: Хот, тосгон бусад суурины ангиллын газар дахь газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал

№	Аймаг, нийслэлийн нэр	Төлөвлөсөн		Хэрэгжсэн	
		Газрын хэмжээ	Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсан байршлын тоо	Газрын хэмжээ	Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн байршлын тоо
1	Архангай	458.2579	3189	189.3285	1917
2	Баян-Өлгий	917.958	5873	162.8559	905
3	Баянхонгор	473.34	834	103.5889	120
4	Булган	655.9988	2133	308.3388	1167
5	Говь-Алтай	18631.441	1982	18359.507	805
6	Говь-Сүмбэр	255.7	1002	226.16	939
7	Дархан-Уул	547.0104	103	200.414	75
8	Дорноговь	63457.728	1051	48810.731	803
9	Дорнод	8604.4217	5828	4960.5027	4544
10	Дундговь	230.94	921	548.474	2838
11	Завхан	3591.408	1359	631.0807	1311
12	Орхон	108.64	46	94.89	119
13	Өвөрхангай	732.8944	5632	440.6763	2052
14	Өмнөговь	165105.84	1922	166538.48	1222
15	Сүхбаатар	151.13	1468	29.6341	272
16	Сэлэнгэ	3095.369	5798	1429.059	3543.6
17	Төв	4644.2622	24141	2361.5859	16437
18	Увс	654.0215	1579	415.122	866
19	Ховд	1722.433	4736	247.607	1986
20	Хөвсгөл	1099.2896	2688	681.935	2056
21	Хэнтий	1004.9272	2483	630.9711	2043
22	Улаанбаатар	679.81	3135	1417.0481	8094
Нийт дүн		276822.82	73640	248787.99	52428



Зураг 1.10.1.1: Хот тосгон, бусад суурин газрын төлөвлөгөөний хэрэгжилтийг байршлын тоогоор нь 2017, 2018 онтой харьцуулсан байдал



Зураг 1.10.1.2: Хот суурины ангиллын газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ

Газар зохион байгуулалтын 2017 оны хот, тосгон бусад суурины ангиллын газрын төлөвлөгөөний хэрэгжилтийг 2018 онтой харьцуулахад:


Говь-Сүмбэр 94 хувь, Дундговь аймаг 308 хувь, Завхан 96 хувь, Орхон 259 хувь, Хэнтий 82 хувь, Хөвсгөл 76 хувь, Дорнод 78 хувь, Дорноговь 76 хувь, Архангай 60 хувь, Дархан-Уул 73 хувьтай, Булган 55 хувь, Увс аймаг 55 хувь, Төв аймаг 68 хувьтай байгаа нь хэрэгжилт сайн байна.

Харин төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй Баян-Өлгий 15 хувь, Баянхонгор 14 хувь, Говь-Алтай 41 хувь, Өвөрхангай 36 хувь, Сүхбаатар 19 хувь, Ховд 42 хувьтай байгаа нь хэрэгжилт хангалтгүй биелэлттэй байна.

Хүснэгт 1.10.1.2: 2017, 2018 онуудын төлөвлөгөөний хэрэгжилтийг харьцуулсан байдал

Аймгийн нэр	2017	2018	Аймгийн нэр	2017	2018
Архангай	42.67	60.11	Архангай	42.7%	60%
Баян-Өлгий	93.43	15.41	Баян-Өлгий	93.4%	15%
Баянхонгор	67.17	14.39	Баянхонгор	67.2%	14%
Булган	45.26	54.71	Булган	45.3%	55%
Говь-Алтай	15.43	40.62	Говь-Алтай	15.4%	41%
Говьсүмбэр	74.24	93.71	Говьсүмбэр	74.2%	94%
Дархан-Уул	32.89	72.82	Дархан-Уул	32.9%	73%
Дорноговь	57.08	76.40	Дорноговь	57.1%	76%

Дорнод	51.79	77.97	Дорнод	51.8%	78%
Дундговь	72.26	308.14	Дундговь	72.3%	308%
Завхан	91.90	96.47	Завхан	91.9%	96%
Орхон	136.96	258.70	Орхон	137.0%	259%
Өвөрхангай	39.66	36.43	Өвөрхангай	39.7%	36%
Өмнөговь	10.02	63.58	Өмнөговь	10.0%	64%
Сүхбаатар	50.44	18.53	Сүхбаатар	50.4%	19%
Сэлэнгэ	27.11	61.12	Сэлэнгэ	27.1%	61%
Төв	61.51	68.09	Төв	61.5%	68%
Увс	40.82	54.84	Увс	40.8%	55%
Ховд	50.00	41.88	Ховд	50.0%	42%
Хөвсгөл	62.64	76.49	Хөвсгөл	62.6%	76%
Хэнтий	57.35	82.28	Хэнтий	57.4%	82%




Зураг 1.10.1.3: 2017-2018 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний харьцуулалт /хувиар/

Хөдөө аж ахуйн газрын төлөвлөлтийн хэрэгжилт


Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөний хөдөө аж ахуйн ангиллын газарт нийт 12117 байршил бүхий 6605510.4 га газрыг төлөвлөснөөс 9654 байршилд 4492232.2 га газрыг эзэмшүүлэх болон өмчлүүлэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 1.10.1.3: Хөдөө аж ахуйн ангиллын газар дахь Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал

№	Аймаг, нийслэлийн нэр	Төлөвлөсөн		Хэрэгжсэн	
		Газрын хэмжээ	Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсан байршлын тоо	Газрын хэмжээ	Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн байршлын тоо
1	Архангай	255286.65	293	14164.12	391
2	Баян-Өлгий	9649.44	930	9641.5	791
3	Баянхонгор	368591.48	1052	279260.05	360
4	Булган	376886.46	444	281390.57	262
5	Говь-Алтай	679676.71	789	51780.46	448
6	Говь-Сүмбэр	30014.71	56	30069.71	36
7	Дархан-Уул	504.89	28	511.19	22
8	Дорноговь	332741.44	168	320178.13	128
9	Дорнод	193273.03	708	138575.02	627
10	Дундговь	4961.0068	620	244.1604	479
11	Завхан	279082.27	439	95525.32	269
12	Орхон	18295.83	24	1416.41	20
13	Өвөрхангай	346971.91	930	308831.98	690
14	Өмнөговь	37777.63	364	11394.05	255
15	Сүхбаатар	51	101	8403.583	17
16	Сэлэнгэ	429846.13	849	471176.88	1016
17	Төв	452889.77	819	450637.39	810
18	Увс	885139.83	599	879721.88	502
19	Ховд	211953.09	157	149426.55	66
20	Хөвсгөл	1592843.6	1644	959117.28	1894
21	Хэнтий	98360.754	1082	30053.254	550
22	Улаанбаатар	712.8	21	712.77	21
Нийт дүн		6605510.4	12117	4492232.2	9654



Зураг 1.10.1.4: ХАА-н ангиллын газрын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссан арга хэмжээ /байршлын тоогоор/



Зураг 1.10.1.5: Хөдөө аж ахуйн газрын төлөвлөлтийн хэрэгжилтийг байршлын тоогоор нь 2017, 2018 онтой харьцуулсан байдал

Газар зохион байгуулалтын 2017 оны хөдөө аж ахуйн ангиллын газрын төлөвлөгөөний хэрэгжилтийг 2018 онтой харьцуулахад:


Архангай аймаг 133 хувь, Баян-Өлгий аймаг 85 хувь, Булган аймаг 59 хувь, Говь-Алтай аймаг 57 хувь, Дархан-Уул аймаг 79 хувь, Дорноговь аймаг 76 хувь, Дорнод аймаг 89 хувь, Дундговь аймаг 77 хувь, Завхан аймаг 61 хувь, Орхон 83 хувь, Өвөрхангай 74 хувь, Өмнөговь аймаг 70 хувь, Төв аймаг 99 хувь, Увс аймаг 84 хувь, Хөвсгөл аймаг 115 хувь, Хэнтий аймаг 51 хувьтай байгаа нь хэрэгжилт сайн байна.

Харин төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй Баянхонгор аймаг 34 хувь, Сүхбаатар аймаг 17 хувь, Ховд аймаг 42 хувьтай байгаа нь хэрэгжилт хангалтгүй биелэлттэй байна.

Хүснэгт 1.10.1.4: 2017, 2018 онуудын төлөвлөгөөний хэрэгжилтийг харьцуулсан байдал

Аймгийн нэр	2017	2018	Аймгийн нэр	2017	2018
Архангай	50.6	133.4	Архангай	51%	133%
Баян-Өлгий	42.9	85.1	Баян-Өлгий	43%	85%
Баянхонгор	38.2	34.2	Баянхонгор	38%	34%
Булган	58.4	59.0	Булган	58%	59%
Говь-Алтай	71.3	56.8	Говь-Алтай	71%	57%

Дархан-Уул	76.9	78.6	Дархан-Уул	77%	79%
Дорноговь	48.4	76.2	Дорноговь	48%	76%
Дорнод	49.3	88.6	Дорнод	49%	89%
Дундговь	115.4	77.3	Дундговь	115%	77%
Завхан	88.3	61.3	Завхан	88%	61%
Орхон	47.4	83.3	Орхон	47%	83%
Өвөрхангай	76.1	74.2	Өвөрхангай	76%	74%
Өмнөговь	100.7	70.1	Өмнөговь	101%	70%
Сүхбаатар	90.0	16.8	Сүхбаатар	90%	17%
Төв	73.6	98.9	Төв	74%	99%
Увс	71.6	83.8	Увс	72%	84%
Ховд	53.4	42.0	Ховд	53%	42%
Хөвсгөл	45.9	115.2	Хөвсгөл	46%	115%
Хэнтий	87.9	50.8	Хэнтий	88%	51%



Зураг 1.10.1.6: 2017-2018 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн харьцуулалт /%-иар/


2018 онд Сэлэнгэ аймаг гэрээгээр ашиглуулах хадлангийн талбайг 14 байршилд төлөвлөсөн боловч хэрэгжилт 2061 байршилд, Говьсүмбэр аймаг уеэц хадлангийн талбай төлөвлөөгүй боловч хэрэгжилт 41964 байгаа нь хэт зөрүүтэй буюу графикт оруулах боломжгүй байгаа тул тайлан төлөвлөгөөг гаргахдаа сайн тулгаж үнэн зөв мэдээлэл гаргаж байх шаардлагатай байна.

1.10.2. Газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөө

Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөний хөдөө аж ахуйн ангиллын газарт нийт 5079272.287 га газрыг болон хот, тосгон бусад суурины газарт 131851.1785 га газрыг, бусад ангиллын газарт 9416289.094 га газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх, хамгаалахаар тус тус төлөвлөжээ. Үүнд:

Хүснэгт 1.10.2.1: Сумдын газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсан газрын хэмжээ

№	Аймаг, нийслэлийн нэр	Хөдөө аж ахуйн газрын ашиглалт, хамгаалалтын 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсан газрын хэмжээ /га-аар/	Хот, тосгон бусад суурины газрын ашиглалт, хамгаалалтын 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсан газрын хэмжээ /га-аар/	Бусад ангиллын газрын 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсан газрын хэмжээ /га-аар/
1	Архангай	157184.21	640.0678	14.3
2	Баян-Өлгий	7173.13	11128.51736	0
3	Баянхонгор	41175.48	1078.2321	427.2
4	Булган	314160.61	21897.5359	1.59
5	Говь-Алтай	270846.37	785.4089	8351334.254
6	Говь-Сүмбэр	6.61	1219.247	0
7	Дархан-Уул	542.19	507.6104	0
8	Дорноговь	203681.58	5766.814182	175147.57
9	Дорнод	87665.18	18034.10219	0
10	Дундговь	249608.41	30956.767	4008.24
11	Завхан	99873.6	12507.9729	17675.09
12	Орхон	18262.09	101.28	0.04
13	Өвөрхангай	287079.55	1271.0613	3542.89
14	Өмнөговь	696.21	7262.868	81161.65
15	Сүхбаатар	80083.118	280.7764	0.1
16	Сэлэнгэ	453239.7	3514.65	1265.51
17	Төв	626857.81	7715.23	91144
18	Увс	509432.7474	401.76	85027.58
19	Ховд	1427026.2	2974.43	43.4
20	Хөвсгөл	219791.032	643.5619	553636.55
21	Хэнтий	24817.66	1089.6252	51765.33
22	Улаанбаатар	68.8	2073.66	93.8
Нийт дүн		5079272.287	131851.1785	9416289.094



Зураг 1.10.2.1: Газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсан газрын хэмжээ /%-иар/

1.11. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНД АШИГЛУУЛЖ БУЙ ГАЗРЫН ТАЙЛАН

2018 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 1147 Сууц өмчлөгчдийн холбоо үйл ажиллагаа явуулж байгаагаас нийслэлд 1032, орон нутагт 115 бүртгэгдсэн байна. 2008 оноос хойшхи СӨХ-ны бүртгэгдсэн байдлыг дараах зурагт харуулав / Зураг 1.11.1/.



Зураг 1.11.1. СӨХ-ны тоо

Хүснэгт 1.11.1. СӨХ-ны орчны газрын баталгаажилтын явц /Улсын хэмжээнд/


Д/Д	Аймаг	Нийт СӨХ-ны тоо	Тооллогонд хамрагдсан СӨХ-ны тоо	Газар ашиглахаар хүсэлт гаргасан СӨХ-ны тоо	Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажсан	Үүнээс						
						Захирамжаар баталгаажигдсан СӨХ-оос газар ашиглах эрхийн гэрээ байгуулсан	Нийт СӨХ-ны ашиглаж байгаа талбайн хэмжээ /м2/	Маргаантай болон судалж байгаа	Захирамж гарахаар хүлээгдэж байгаа	Ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаа СӨХ-ийн тоо	Ерөнхий төлөвлөгөө хийгдсэн СӨХ-ийн тоо	
1	Архангай	1	1	1	1	1	47900.0	0	11	11	0	
2	Баянхонгор	5	5	0	3	3	32925.0	0	0	0	0	
3	Баян-Өлгий	0	0	0	0	0	0	0	0	0	0	
4	Булган	1	1	0	1	1	32197.9	0	0	0	0	
5	Говь-Алтай	5	5	0	5	5	51000.0	0	0	0	0	
6	Говьсүмбэр	4	4	0	4	4	131335.0	0	0	0	0	
7	Дархан-Уул	36	36	30	27	16	562401.0	4	9	0	30	
8	Дорнод	12	12	0	8	8	160579.0	0	0	0	0	
9	Дорноговь	10	10	10	8	8	164567.8	0	2	0	0	
10	Дундговь	1	1	1	1	1	15700.0	0	0	0	0	
11	Завхан	0	0	0	0	0	0	0	0	0	0	
12	Орхон	24	24	24	24	24	853200.0	0	0	0	0	
13	Өвөрхангай	4	0	0	0	4	33415.0	0	0	0	0	
14	Өмнөговь	2	1	1	1	1	9351.7	0	0	0	0	
15	Сүхбаатар	1	1	0	1	1	3500.0	0	0	0	0	
16	Сэлэнгэ	8	8	8	8	8	337199.0	0	0	0	0	
17	Төв	0	0	0	0	0	0.0	0	0	0	0	
18	Увс	1	1	0	1	1	49000.0	0	0	0	0	
19	Ховд	0	0	0	0	0	0	0	0	0	0	
20	Хөвсгөл	0	0	0	0	0	0	0	0	0	0	
21	Хэнтий	0	0	0	0	0	0	0	0	0	0	
22	Нийслэл	1032	482	314	794	794	1322589	0	31	40	40	
Нийт		1147	592	389	887	880	3806860	4	53	51	70	

Тайлант оны байдлаар улсын хэмжээнд нийт 1147 СӨХ-ны 887 нь орчны газраа ашиглах эрхээ аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулж, 880 СӨХ-ны орчны 3806860 м.кв газрыг ашиглуулахаар гэрээ байгуулсан байна.

2. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАН

2.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ҮНДСЭН АНГИЛАЛ, ГАЗАР АШИГЛАЛТЫН ТӨРӨЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, ШИЛЖИЛТИЙН ҮНДЭСЛЭЛ /МАЯГТ ГТ-1, 5/

2018 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын газрын нэгдмэл санд хөдөө аж ахуйн газар 114809.2 мянган га буюу 73.4 хувь, хот, тосгон бусад суурины газар 859.7 мянган га буюу 0.5 хувь, зам, шугам сүлжээний газар 474.3 мянган га буюу 0.3 хувь, ойн сан бүхий газар 14341.4 мянган га буюу 9.2 хувь, усны сан бүхий газар 686.1 мянган га буюу 0.4 хувь, улсын тусгай хэрэгцээний газар 25240.9 мянган га буюу 16.1 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.1/



Зураг 2.1.1: Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал тус бүрийн эзлэх хувь

2018 оны газрын нэгдмэл сангийн тайланг 2017 оны тайлангийн дүнтэй харьцуулахад хөдөө аж ахуйн газар 34.4 мянган га-гаар хасагдаж, хот тосгон, бусад суурины газар 19.6 мянган га, зам, шугам сүлжээний газар 2.6 мянган га, ойн сан бүхий газар 0.2 мянган га, улсын тусгай хэрэгцээний газар /ГТ-4 тайлангийн тайлбарыг харна уу/ 11.9 мян.га-гаар тус тус нэмэгдэж, усны сан бүхий газарт өөрчлөлт ороогүй байна /Хүснэгт 2.1.1/.

Хүснэгт 2.1.1: Улсын газрын нэгдмэл сангийн ангиллын өөрчлөлтийн товчоо / мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2017	2018	Зөрүү /мян га/
I	Хөдөө аж ахуйн газар	114843.6	114809.2	-34.4
1	Бэлчээрийн газар	110429.3	110391.6	-37.7
2	Хадлангийн талбай	1710.2	1709.1	-1.1
3	Тариалангийн газар	1086.8	1100.8	14.0
4	Атаршсан газар	241.0	231.6	-9.4

5	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	116.6	116.4	-0.2
6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	1259.7	1259.7	0.0
II	Хот, тосгон бусад суурины газар	840.1	859.7	19.6
7	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	78.0	79.3	1.3
8	Нийтийн эдэлбэр газар	324.2	322.8	-1.4
9	Үйлдвэрийн газар	44.1	44.9	0.8
10	Уурхайн газар	319.0	333.4	14.4
11	Гэр хорооллын газар	74.8	79.3	4.5
III	Зам, шугам сүлжээний газар	471.7	474.3	2.6
12	Авто замын газар	335.6	335.7	0.1
13	Төмөр замын газар	31.8	31.8	0.0
14	Агаарын тээврийн газар	8.8	9.2	0.4
15	Шугам сүлжээний газар	95.5	97.6	2.1
16	Усан тээврийн буудлын газар	0.0	0.0	0.0
IV	Ойн сан бүхий газар	14341.3	14341.5	0.2
17	Ой модоор бүрхэгдсэн газар	12188.9	12188.6	-0.3
18	Ой модыг нь огтолсон газар	142.9	143.5	0.6
19	Мод үржүүлгийн газар	65.0	64.2	-0.8
20	Ой тэлэн ургах нөөц газар	743.4	743.3	-0.1
21	Ойн сангийн бусад газар	1201.1	1201.9	0.8
V	Усны сан бүхий газар	686.1	686.1	0.0
22	Гол мөрний эзлэх газар	228.5	228.5	0.0
23	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	443.6	443.6	0.0
25	Горхи, булаг, шандны эзлэх газар	12.4	12.4	0.0
24	Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	1.6	1.6	0.0
VI	Улсын тусгай хэрэгцээний газар	25228.8	25240.8	11.9
26	Улсын тусгай хамгаалалттай газар	21140.9	21140.9	0.0
27	Улсын хилийн зурвас газар	3112.0	3112.0	0.0
28	Улсын батлан хамгаалах зориулалтын газар	124.1	124.1	0.0
29	Гадаадын дипломат, консул, төлөөлөгчийн газар	0.0	0.0	0.0
30	ШУ, туршилт, цаг уурын ажиглалтын талбай	23.0	34.9	11.9
31	Аймаг дундын отрын бэлчээр	691.4	691.4	0.0
32	Улсын тэжээлийн сангийн хадлангийн газар	110.9	110.9	0.0
33	Газрын тосны гэрээт талбай	24.5	24.5	0.0
34	Чөлөөт бүсийн газар	2.1	2.1	0.0
НИЙТ ДҮН		156411.6	156411.6	

2.1.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

Хөдөө аж ахуйн газар 114809.2 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 73.4 хувийг эзэлж байна.

Хөдөө аж ахуйн газарт бэлчээрийн газар 110391.6 мянган га буюу 96.1 хувь, хадлангийн газар 1709.1 мянган га буюу 1.5 хувь, тариалангийн газар 1100.8 мянган га буюу 1.0 хувь, атаршсан газар 231.6 мянган га буюу 0.2 хувь, хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр газар 116.4 мянган га буюу 0.1 хувь, хөдөө аж ахуйн хэрэгцээнд тохиромжгүй газар 1259.7 мянган га буюу 1.1 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 2.1.2. Хөдөө аж ахуйн газрын өөрчлөлт /мян га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2017	2018	Зөрүү /мян га/
I	Хөдөө аж ахуйн газар	114843.6	114809.2	-34.1
1	Бэлчээрийн газар	110429.3	110391.6	-37.4
2	Хадлангийн талбай	1710.2	1709.1	-1.1
3	Тариалангийн газар	1086.8	1100.8	14.0
4	Атаршсан газар	241.0	231.6	-9.4
5	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	116.6	116.4	-0.2
6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	1259.7	1259.7	0.0

Бэлчээрийн газар

Бэлчээрийн газар нь 2017 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 37.1 мянган га-аар хасагдсан байна. Тайлант онд бэлчээрийн газраас хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр газар, зам, шугам сүлжээний газар, хот, тосгон бусад суурины газар, ойн сан бүхий газрын мод үржүүлгийн газрын ангилал руу шилжилт хийгдсэн байна.

Хадлангийн газар

Хадлангийн газар нь 2017 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 1.1 мянган га-аар хасагдсан байна.

2018 онд Баян-Өлгий аймагт 10.0 га, Орхон аймагт 4.2 га, Ховд аймагт 23.7 га, Увс аймагт 125.2 талбайг хадлангийн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагад шинээр эзэмшүүлсэн боловч Завхан аймгийн Нөмрөг сумын Хөдрөг багт 1200 га газрыг “Тогтвортой амьжиргаа 2” төслөөр малчдын бүлэг хашиж ашиглаж байсан нь захирамж шийдвэргүйгээр ашиглаж байсан бөгөөд уг газрын чөлөөлж хашсан байсан хашааг буулгаж, хадлангийн талбайн зориулалтаар ашиглаж байсан талбайг бэлчээрт шилжүүлснээр улсын хэмжээнд 1.1 мян.га-гаар буурсан дүнтэй байна.

Тариалангийн газар


Тариалангийн газар нь 2017 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 14.0 мянган га-аар нэмэгдсэн байна.

Хүснэгт 2.1.3. Тариалангийн газрын өөрчлөлтийн товчоо /га/

№	Аймгийн нэр	2017	2018	Зөрүү
1	Архангай	23366.34	26457.3	3091.0
2	Баянхонгор	2700.75	2196.3	-504.5
3	Баян-Өлгий	2609.85	2659.9	50.0
4	Булган	88827.5967	89374.4	546.8
5	Говь-Алтай	5141.18	5189.3	48.1
6	Говьсүмбэр	3320.02	3338.0	18.0
7	Дархан-Уул	34205.46	34205.5	0.0
8	Дорноговь	546.225	546.2	0.0
9	Дорнод	101168.91	101817.7	648.8
10	Дундговь	701.32	703.3	2.0
11	Завхан	6401.324	10466.2	4064.9
12	Орхон	5079.62	5101.7	22.1
13	Өвөрхангай	24852.38	25365.1	512.7
14	Өмнөговь	749.84	764.0	14.2
15	Сүхбаатар	16725.7427	16727.8	2.1
16	Сэлэнгэ	315270.467	315240.7	-29.8
17	Төв	258245.01	258781.2	536.2
18	Увс	66599.26	70801.6	4202.3
19	Ховд	9044.852	9293.7	248.8
20	Хөвсгөл	33630.08	33931.1	301.0
21	Хэнтий	80147.89	80147.9	0.0
22	Нийслэл	7451.85022	7715.5	263.6
Нийт дүн		1086785.97	1100824.2	14038.2

2017 оны дүнтэй харьцуулахад тариалангийн газар хамгийн их нэмэгдсэн нь Архангай аймагт 3091.0 га, Булган аймагт 546.8 га, Дорнод аймагт 648.8 га, Завхан аймагт 4064.9 га байна. Эдгээр нь атаршсан талбайг эргүүлэн үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тариалах зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад шинээр эзэмшүүлсэнтэй холбоотойгоор гарсан өөрчлөлт юм.

1990 оноос хойшхи тариалангийн газрын талбайн хэмжээг дараах зурагт үзүүлэв /Зураг 2.1.2/.




Зураг 2.1.2: Тариалангийн газрын өөрчлөлт /мян.га/

2.1.2. ХОТ, ТОСГОН, БУСАД СУУРИНЫ ГАЗАР

Хот, тосгон бусад суурины газар 859.7 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.5 хувийг эзэлж байна.

Хот, тосгон, бусад суурины газарт барилга, байгууламжийн дэвсгэр газар 79.3 мянган га буюу 9.2 хувийг, нийтийн эдэлбэр газар 322.8 мянган га буюу 37.5 хувийг, үйлдвэрийн газар 44.9 мянган га буюу 5.2 хувийг, уурхайн газар 333.4 мянган га буюу 38.8 хувийг, гэр хорооллын газар 79.3 мянган га буюу 9.2 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.2.1./.



Зураг 2.1.2.1. Хот тосгон, бусад суурин газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.2.1. Хот, тосгон, бусад суурин газрын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2017	2018	Зөрүү /мян га/
II	Хот, тосгон бусад суурины газар	840.1	859.7	19.6
1	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	78.0	79.3	1.3
2	Нийтийн эдэлбэр газар	324.2	322.8	-1.4
3	Үйлдвэрийн газар	44.1	44.9	0.8
4	Уурхайн газар	319.0	333.4	14.4
5	Гэр хорооллын газар	74.8	79.3	4.5

2018 оны тайлангийн дүнгээр гэр хорооллын газар 4.5 мянган га-аар өссөн нь нийслэл, орон нутагт Монгол Улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмшүүлж, өмчлүүлж байгаатай холбоотой юм. Мөн тайлант онд уурхайн газар 14.4 мянган га-аар өссөн нь Дорноговь аймагт уурхайн газар 45.0 мян. га, Баянхонгор, Дорнод, Дундговь, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгуудад тус бүр 174.2 га-гаас 4087.3 га-аар тус тус нэмэгдсэнтэй холбоотой юм.

Дээрх аймгуудын нутаг дэвсгэрт илэрсэн ашигт малтмалын нөөцөд тулгуурлан мэргэжлийн эрх бүхий байгууллагаас олгосон ашиглалтын лицензийг үндэслэн 2018 онд ашигт малтмал олборлох зориулалтаар үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад уул уурхайн зориулалтаар ашиглуулах шийдвэр гаргаж, гэрээ байгуулсан байна.


Үйлдвэрийн газар улсын хэмжээнд 821.9 га-гаар нэмэгдэж, 71.5 га-гаар хасагдсан байна. Үйлдвэрийн газрын хэмжээ Баян-Өлгий аймагт 24.4 га-гаар хасагдсан нь

Газрын кадастрын Лэнд менежер программ хангамжийг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор аймгийн хэмжээнд зөрүүтэй мэдээллийн захирамж шинэчлэх ажил зохион байгуулж өөрчлөлтүүдийг Улсын бүртгэлд тусгасантай холбоотой байна. Дорнод аймгийн Матад суманд үйлдвэрийн зориулалтаар олгогдсон байсан 9 га газрыг хүчингүй болгон хөдөө аж ахуйн газрын ангилалд шилжүүлсэн байна. Мөн Дорноговь аймагт үйлдвэрийн зориулалтаар эзэмшүүлж байсан 41.5 га газрыг цуцалж, бусад ангилалд шилжүүлсэн байна.

2.1.3. ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР

Зам, шугам сүлжээний газар 474.3 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.3 хувийг эзэлж байгаа бөгөөд 2017 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 2.6 мянган га-аар нэмэгдсэн байна /Хүснэгт 2.1.3.1/.

Зам, шугам сүлжээний газарт авто замын газар 335.7 мянган га буюу 72.1 хувийг, төмөр замын газар 31.8 мянган га буюу 6.8 хувийг, агаарын тээврийн газар 9.2 мянган га буюу 2.0 хувийг, шугам сүлжээний газар 97.6 мянган га буюу 20.9 хувийг тус тус эзэлж байна.



Зураг 2.1.3.1. Зам, шугам сүлжээний газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.3.1. Зам, шугам, сүлжээний газрын ангиллын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2017	2018	Зөрүү /мян га/
III	Зам, шугам сүлжээний газар	471.7	474.3	2.6
1	Авто замын газар	335.6	335.7	0.1
2	Төмөр замын газар	31.8	31.8	0.0
3	Агаарын тээврийн газар	8.8	9.2	0.4
4	Шугам сүлжээний газар	95.5	97.6	2.1
4	Усан тээврийн буудлын газар	0.0	0.0	0.0

Дэд бүтцийн салбарын бүтээн байгуулалт жилээс жилд өсөн нэмэгдэж байгаатай холбогдон зам, шугам сүлжээний газрын хэмжээ мөн адил өсөн нэмэгдэж байна.

Сүүлийн жилүүдэд авто зам, шугам сүлжээний газрын хэмжээ тогтмол нэмэгдэж ирсэн нь тус салбар дахь бүтээн байгуулалт болоод тухайн газруудыг холбогдох журмын

дагуу газрын улсын бүртгэлд бүртгэж, хариуцах эзэнтэй болгосонтой холбоотой юм.


Агаарын тээврийн зориулалтаар ашиглагдаж байгаа газрын хэмжээ Дорнод аймагт 290 га газраар нэмэгдсэн нь Хэрлэн болон Баянтүмэн сумын нутаг дэвсгэрийг дамнан байрлаж буй нисэх буудлын хэмжээг дахин тодорхойлж, захирамж шийдвэр гарган шинэчилсэнтэй холбоотой байна. Мөн Увс аймагт “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх ажил”-ын хүрээнд хийгдсэн хэмжилт зураглалын ажлын үр дүнд нисэх буудлын талбайн бодит хэмжээг шинэчлэн тогтоосноор агаарын тээврийн газрын хэмжээ нэмэгдсэн байна.

Шугам сүлжээний доорх газрын хэмжээ бүх аймагт нэмэгдсэнээр улсын хэмжээнд нийтдээ 2.1 мян.га-гаар нэмэгдсэн дүнтэй байна.

2.1.4. ОЙН САН БҮХИЙ ГАЗАР

Ойн сан бүхий газар 14341.5 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 9.2 хувийг эзэлж байна.

Ойн сан бүхий газарт ойгоор бүрхэгдсэн газар 12188.6 мянган га буюу 85.0 хувийг, ой модыг нь огтолсон газар 143.5 мянган га буюу 1.0 хувийг, мод үржүүлгийн газар 64.2 мянган га буюу 0.4 хувийг, ой тэлэн ургах нөөц газар 743.3 мянган га буюу 5.2 хувийг, ойн сангийн бусад газар 1201.9 мянган га буюу 8.4 хувийг тус тус эзэлж байна.



Зураг 2.1.4.1. Ойн сан бүхий газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.4.1. Ойн сан бүхий газрын өөрчлөлт /мян.га/


№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2017	2018	Зөрүү /мян га/
IV	Ойн сан бүхий газар	14341.3	14341.5	0.2
1	Ой модоор бүрхэгдсэн газар	12188.9	12188.6	-0.3
2	Ой модыг нь огтолсон газар	142.9	143.5	0.6
3	Мод үржүүлгийн газар	65.0	64.2	-0.8
4	Ой тэлэн ургах нөөц газар	743.4	743.3	-0.1
5	Ойн сангийн бусад газар	1201.1	1201.9	0.8

2018 онд мод үржүүлгийн газар 0.8 мянган га-гаар хасагдсан нь Дорнод аймгийн Халхгол суманд мод үржүүлгийн 1000 га газрыг ойн сангийн бусад газарт шилжүүлсэн байна. Мөн Дорнод, Сэлэнгэ аймагт ойн сан бүхий газрын үндсэн ангилал дотроо шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна.

2.1.5. УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР

Усны сан бүхий газар 686.1 мянган га буюу нийт газар нутгийн 0.4 хувийг эзэлж байна.

Усны сан бүхий газарт мөрөн, гол, горхи 228.5 мянган га буюу 33.3 хувийг, нуур, цөөрөм 443.6 мянган га буюу 64.7 хувийг, горхи, булаг, шанд 12.4 мянган га буюу 1.8 хувийг, мөнх цас, мөсөн гол 1.6 мянган га буюу 0.2 хувийг тус тус эзэлж байна. Тайлант онд усны сан бүхий газарт өөрчлөлт ороогүй байна.




Зураг 2.1.5.1. Усны сан бүхий газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.5.1. Усны сан бүхий газрын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2017	2018	Зөрүү /мян га/
V	Усны сан бүхий газар	686.1	686.1	0.0
1	Гол мөрний эзлэх газар	228.5	228.5	0.0
2	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	443.6	443.6	0.0
3	Горхи, булаг, шандны эзлэх газар	12.4	12.4	0.0
4	Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	1.6	1.6	0.0

2.2. УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР /МАЯГТ ГТ-4/

2018 оны байдлаар Улсын тусгай хэрэгцээний газрын нийт хэмжээ 25240.9 мянган га талбай буюу улсын нийт нутаг дэвсгэрийн 16.13 хувийг эзэлж байна.



Зураг 2.2.1: Улсын тусгай хэрэгцээний газрын эзлэх хувь

Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд улсын тусгай хамгаалалттай газар 21140.8 мянган га буюу 83.76 хувийг, улсын хилийн зурвас газар 3111.9 мянган га буюу 12.33 хувийг, улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 124.1 мянган га буюу 0.49 хувийг, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар 0.03 мянган га буюу 0.0001 хувийг, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 34.96 мянган га буюу 0.14 хувийг, аймаг дундын отрын бэлчээр 691.41 мянган га буюу 2.74 хувийг, улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай 110.94 мянган га буюу 0.44 хувийг, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай 24.47 мянган га буюу 0.1 хувийг, чөлөөт бүсийн газар 2.11 мянган га буюу 0.01 хувийг тус тус эзэлж байна.


Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 273 дугаар тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт 12000 га газрыг “Майдар хот” төсөл хэрэгжүүлэх буюу Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авч хөдөө аж, ахуйн газраас шилжсэн өөрчлөлтийг ГТ-4 тайланд тусгав.

Хүснэгт 2.2.1: Улсын тусгай хэрэгцээний газрын өөрчлөлт /га/

Д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	2017	2018	Зөрүү
VI	Улсын тусгай хэрэгцээний газар	25228899.26	25240899.26	12000.00
1	Улсын тусгай хамгаалалттай газар, бүгд	21140880.62	21140880.62	0.00
а	дархан цаазат газар	10919403.00	10919403.00	0.00
б	байгалийн цогцолборт газар	8097821.00	8097821.00	0.00
в	байгалийн нөөц газар	2044351.62	2044351.62	0.00
г	дурсгалт газар	79305.00	79305.00	0.00
2	Улсын хилийн зурвас газар	3111994.94	3111994.94	0.00
3	Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	124097.61	124097.61	0.00

4	Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар	33.68	33.68	0.00
5	Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	22960.21	34960.21	12000.00
6	Аймаг дундын отрын бэлчээр	691413.80	691413.80	0.00
7	Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай	110940.00	110940.00	0.00
8	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай	24470.00	24470.00	0.00
9	Эдийн засгийн чөлөөт бүсийн газар	2108.40	2108.40	0.00

Улсын тусгай хэрэгцээний газар дээрх газар ашиглалтад тавих төрийн хяналт сул байгаагаас үүдэн тус ангиллын газрыг зөвшөөрөгдөөгүй зориулалтаар ашиглах, орон нутгийн Засаг даргын захирамж, шийдвэрээр өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газартай байрлалын хувьд давхардуулан ашиглуулах зэрэг зөрчил дутагдал нэмэгдэх болсон. Эдгээрийн эх үүсвэр нь шийдвэр гаргаж буй этгээд олон, нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан хөтөлдөггүйгээс үүдэлтэй гэж дүгнэж байна.



Зураг 2.2.2: Улсын тусгай хэрэгцээний газрын ангиллын талбайн хэмжээ /га/


Тайлант онд Улсын тусгай хэрэгцээний газар тэр дундаа Улсын тусгай хамгаалалттай газар, Чөлөөт бүсийн газрын бүртгэл, мэдээллийг сайжруулах, тус ангилалын газруудад эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглах эрхийг баталгаажуулах, улсын Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санг баяжуулах, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран тус яам болон харьяа Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын нийт захиргаадад Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер программ хангамжийг ашиглуулж эхэллээ.

Тус ажлын хүрээнд Улсын тусгай хамгаалалттай газарт газар ашиглах эрх зүйн харилцаа үүсэн нийт 2507 нэгж талбарын мэдээллийг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбох, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын нийт захиргаадын мэргэжилтэн, албан хаагчдад Лэнд менежер программ хангамжийн сургалтыг зохион байгуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зэрэг томоохон ажлуудыг богино хугацаанд амжилттай хийж гүйцэтгэлээ. Цаашид

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Улсын тусгай хамгаалалттай газарт газар ашиглах эрх зүйн харилцааг шинэчлэх, боловсронгуй болгох чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран ажиллахаар төлөвлөөд байна.


2.3. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-2/

2018 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 6975125.94 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоод байна. Үүнээс 62217.34 га-г өмчилж, 6501625.83 га-г эзэмшиж, 383664.89 га газрыг ашиглаж байна. Мөн бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллага 27617.87 га газрыг тус тус ашиглаж байна /Зураг 2.3.1/.




Зураг 2.3.1: 2018 оны байдлаар өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газар /хувиар/

Тайлант оны газар, өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн нийт талбайг 2017 онтой харьцуулбал 180367.1 га-гаар өссөн байна /Зураг 2.3.2/.




Зураг 2.3.2: Нийт өмчлөл, эзэмшил, ашиглалтанд буй газрыг урьд оны дүнтэй харьцуулсан байдал /га-гаар/


Газрын эрхийн төрлөөр 2017 оны үзүүлэлттэй харьцуулахад иргэн, хуулийн этгээдийн өмчлөлийн газар 62217.34 га болж 4450.08 га-аар /Зураг 2.3.3/, иргэн, хуулийн этгээдийн ашиглаж буй газар 383664.89 га болж 80498.88 га-гаар /Зураг 2.3.6/, иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн газар 6501625.83 га болж 95659.70 га-аар /Зураг 2.3.4/ тус тус өссөн дүнтэй байна. Харин бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар 27617.87 га болж 241.56 га-гаар хасагдсан байна /Зураг 2.3.5/.




Зураг 2.3.3: Өмчлүүлсэн газар /га-гаар/



Зураг 2.3.4: Эзэмшүүлсэн газар /га-гаар/




Зураг 2.3.5: Бусдад ашиглуулж буй эзэмшлийн газар /га-гаар/



Зураг 2.3.6: Ашиглуулсан газар /га-гаар/

Газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангиллаар авч үзвэл хөдөө аж ахуйн газарт 1396824.65 га, хот тосгон, бусад суурины газарт 601998.83 га, зам, шугам сүлжээний газарт 178353.66 га, ойн сан бүхий газарт 680439.91 га, усны сан бүхий газарт 83213.67 га, улсын тусгай хэрэгцээний газарт 4034295.21 га газар өмчлөл, эзэмшил, ашиглалтанд олгогдоод байна /Зураг 2.3.7/.




Зураг 2.3.7: Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг газрын нэгдмэл сангийн ангиллаар үзүүлсэн байдал /хувиар/

Хүснэгт 2.3.1: Газрын нэгдмэл сангийн ангилал дахь эрхийн төрлийн өөрчлөлт

д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2017 он	2018 он	Зөрүү
1	Хөдөө аж ахуйн газар	өмчлөгч	131.6	132.0	0.4
		эзэмшигч	1297347	1322899.1	25552.1
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	7144.3	7135.5	-8.8
		ашиглагч	42403.1	66658.1	24255.0
		нийт	1347026.1	1396824.7	49798.6
2	Хот, тосгон, бусад суурины газар	өмчлөгч	57635.6	62085.2	4449.6
		эзэмшигч	314841.6	327452.5	12610.9
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	17018.3	16731.3	-287.0
		ашиглагч	146762.7	195729.8	48967.1
		нийт	536258.1	601998.8	65740.7
3	Зам, шугам шүлжээний газар	эзэмшигч	148320.6	148248.6	-72.0
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	3367.7	3370.8	3.1
		ашиглагч	19618.9	26734.3	7115.4
		нийт	171307.1	178353.6	7046.5
4	Ойн сан бүхий газар	эзэмшигч	673584.5	674502.4	917.9
		ашиглагч	5935.2	5937.6	2.4
		нийт	679519.7	680439.9	920.2
5	Усны сан бүхий газар	эзэмшигч	86210.3	83213.7	-2996.6
		ашиглагч	2222	0.0	-2222.0
		нийт	88432.3	83213.7	-5218.6
6	Улсын тусгай хэрэгцээний газар	эзэмшигч	3888663	3945309.7	56646.7
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	329.1	380.4	51.3
		ашиглагч	88446.2	88605.2	159.0
		нийт	3977438.3	4034295.2	56856.9


2.4. ГАЗРЫН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-3/

2018 онд улсын хэмжээнд нийт 1091873 газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч байгаа нь өмнөх оныхоос нийт дүнгээрээ 55756-аар өссөн байна /Зураг 2.4.1/.




Зураг 2.4.1: Нийт өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг урьд оны дүнтэй харьцуулсан байдал /тоогоор/

Тайлант онд газар өмчлөгч 615454, эзэмшигч 473919, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 1333, газар ашиглагч 1167 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тус тус байна /Зураг 2.4.2/.




Зураг 2.4.2: Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдын хувь


Газрын эрхийн төрлөөр 2018 оны үзүүлэлттэй харьцуулахад газар өмчлөгчийн тоо 615454 болж, 44683-аар /Зураг 2.4.3/, газар эзэмшигчийн тоо 473919 болж 10606-аар /Зураг 2.4.4/, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо 1333 болж 272-оор /Зураг 2.4.5/, газар ашиглагчийн тоо 1167 болж 195-аар тус тус өссөн дүнтэй байна /Зураг 2.4.6/.




Зураг 2.4.3: Газар өмчлөгч /тоогоор/



Зураг 2.4.4: Газар эзэмшигч /тоогоор/



Зураг 2.4.5: Бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага /тоогоор/



Зураг 2.4.6: Газар ашиглагч /тоогоор/

Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангиллаар үзүүлбэл хөдөө аж ахуйн газарт 195757, хот тосгон, бусад суурины газарт 887121, зам, шугам сүлжээний газарт 2780, ойн сан бүхий газарт 4071, усны сан бүхий газарт 64, улсын тусгай хэрэгцээний газарт 2080 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байна /Зураг 2.4.7/.

Мөн 2018 онд зарим аймгуудын хэмжээнд өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын мэдээллийг нэгтгэх “Газрын бүртгэл” аяныг зохион байгуулсан бөгөөд тус ажлын хүрээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэдийн тоог бодитой болгох ажлыг зохион байгуулан газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэдийн улсын бүртгэлийг Засаг даргын захирамжтай тулган цэгцэлснээр өмнөх оны газар эзэмшигчийн тооноос Увс аймгийн хэмжээнд 2375 иргэн, Ховд аймгийн хэмжээнд 795 иргэнээр тус тус багассан дүн гарсан байна.



Зураг 2.4.7: Газрын нэгдмэл сангийн ангиллаар үзүүлсэн байдал /эзлэх хувь/

Хүснэгт 2.4.1: Газар эзэмшигч, ашиглагчдын өөрчлөлт /газрын нэгдмэл сангийн ангиллаар/

д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2017	2018	Зөрүү
1	Хөдөө аж ахуйн газар	өмчлөгч	109	88	-21
		эзэмшигч	193969	195448	1479
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	1061	1333	272
		ашиглагч	48	50	2
		нийт	195187	196919	1732
2	Хот, тосгон, бусад суурины газар	өмчлөгч	570662	615365	44703
		эзэмшигч	262421	270769	8348
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	170	186	16
		ашиглагч	690	801	111
		нийт	833943	887121	53178
3	Зам, шугам шүлжээний газар	эзэмшигч	2072	2461	389
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	29	53	24
		ашиглагч	208	265	57
		нийт		2779	2779
4	Ойн сан бүхий газар	эзэмшигч	3712	4017	305
		ашиглагч	6	30	24
		нийт	3718	4047	329
5	Усны сан бүхий газар	эзэмшигч	61	64	3
		ашиглагч	0	0	0
		нийт	61	64	3
6	Улсын тусгай хэрэгцээний газар	эзэмшигч	1078	1160	82
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	695	899	204
		ашиглагч	20	21	1
		нийт	1793	2080	287

2.5. ГАЗАРТ УЧРУУЛСАН ХОХИРЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-6/

Аймаг, нийслэлээс ирүүлсэн “Газарт учруулсан хохирлын тайлан”-г ГТ-6 маягтаар хүлээн авч, улсын хэмжээнд нэгтгэн дүгнэхэд 2018 онд улсын хэмжээнд нийт 7355540.6 га газарт хохирол учирсан байна. Үүнийг ангилан үзвэл тариалангийн 106237.8 га, бэлчээр ба бусад өвслөг ургамал газрын 7.0 сая га, хот тосгон, бусад суурин газрын 21533.0 га, ойн сан бүхий газрын 209316.9 га, усны сан бүхий газрын 175.3 га газарт тус тус хохирол учирсан бол 18272.0 га газар ухагдаж эвдэрсэн байна.


2.5.1. ТАРИАЛАНГИЙН ГАЗАР

Тариалангийн газрын хохирлын тайланг салхи, усны элэгдэл эвдрэлд орсон, үржил шим буурсан, хортон шавьжид нэрвэгдсэн, хөрс бохирдсон, химийн бодисоор бохирдсон, бусад гэсэн 8 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 106237.8 га тариалангийн талбайд хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 1.4 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 35356,4 га-аар илүү байна.

Тариалангийн газарт хамгийн их хохирол учруулсан хүчин зүйл бол мэрэгчид, хортон шавьжийн нөлөө байна. Өөрөөр хэлбэл нийт хохирол учирсан талбайн 63.0 хувь буюу 66969.4 га талбай мэрэгчид, хортон шавьжийн нөлөөнд өртсөн байна.

Хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл үржил шимийн бууралттай 30798.9 га (29,0%), салхины эвдрэлд орсон 6737.3 га (6,3%), онц аюултай ургамалд нэрвэгдсэн 585.8 га (0.6%), бусад 676.9 га (0,6%), усны эвдрэлд орсон 348.5 га, хөрс бохирдсон 34.5 га, химийн бодисоор бохирдсон 50.5 га гэсэн дараалалтай байна.



Зураг 2.5.1.1: Тариалангийн газарт учирсан хохирол, га-аар

Төв, Дархан-Уул, Увс аймгийн тариалангийн газарт хамгийн их хохирол учирсан байна.

2.5.2. БЭЛЧЭЭРИЙН ГАЗАР

Бэлчээрийн газрын хохирлын тайланг талхлагдсан, салхи, усны эвдрэлд орсон, намагжсан, элсний нүүлтэд орсон, мэрэгчид, хортон шавьжид идэгдсэн, цөлжсөн, ашигт малтмалын олборлолтод өртсөн, газрын тосны олборлолтоос бохирдсон гэсэн 8 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 7000005.7 га бэлчээрт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 95.1 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 3859094.4 га-гаар илүү байна.

Бэлчээрийн газарт хамгийн их хохирол учруулсан хүчин зүйл бол мэрэгчид, хортон шавьжийн нөлөө байна. Өөрөөр хэлбэл нийт хохирол учирсан талбайн 70.8 хувь буюу 4956735.4 га талбай мэрэгчид, хортон шавьжийн нөлөөнд өртсөн байна.

Хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл талхлагдсан 1483410.4 га (21,2%), цөлжсөн 353145.4 га (5,0%), элсний нүүлтэд орсон 146596.4 га (2.1%), ашигт малтмалын олборлолтод өртсөн 49074.8 га (0,7%), салхи, усны эвдрэлд орсон 10854.5 га, намагжсан 34.5 га гэсэн дараалалтай байна. Харин газрын тосны олборлолтын улмаас 40.0 га газар бохирдсон байна.



Зураг 2.5.2.1: Бэлчээрт учирсан хохирол, га-аар

Төв, Сүхбаатар, Дундговь аймгийн бэлчээрт хамгийн их хохирол учирсан байна.


2.5.3. ХОТ ТОСГОН, БУСАД СУУРИН ГАЗАР

Хот тосгон, бусад суурин газрын хохирлын тайланг ургамлан бүрхэвчгүй болсон, элсний нүүлтэд орсон, химийн болон цацраг идэвхт бодисоор хордсон, үйлдвэрийн хог хаягдлаар бохирдсон, ахуйн хог хаягдлаар бохирдсон, бусад гэсэн 6 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 21549.3 га хот суурины газарт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 0.3 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 9934.3 га-аар илүү байна.

Хот тосгон, бусад суурин газрын бохирдолд нөлөөлсөн хүчин зүйл бол ахуйн хог хаягдал байна. Өөрөөр хэлбэл нийт хохирол учирсан талбайн 91.1 хувь буюу 19628,0 га газрыг ахуйн хог хаягдлаар бохирдуулсан байна.

Хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл үйлдвэрийн хог хаягдлаар бохирдсон 856.6 га (4,0%), элсний нүүлтэд орсон 565.5 га (2,6%), бусад 456.9 га (2.1%), ургамлан бүрхэвчгүй болсон 26.0 га (0,1%), химийн болон цацраг идэвхт бодисоор хордсон 16.8 га (0,1%) гэсэн дараалалтай байна.



Зураг 2.5.3.1: Хот, тосгон бусад суурины газарт учирсан хохирол, га-аар

Хөвсгөл, Өвөрхангай, Өмнөговь аймагт хамгийн их хохирол учирсан байна.


2.5.4. ОЙН САН БҮХИЙ ГАЗАР

Ойн сан бүхий газрын хохиролын тайланг түймэрт нэрвэгдсэн, өвчин, хортон шавьжинд идэгдсэн, мод бут, сөөг, загийг устгасан, ашигт малтмалын олборлолтод өртсөн, бусад гэсэн 5 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 209316.9 га ойн сан бүхий газарт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 2.8 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 16189.7 га-аар бага байна.

Ойн сан бүхий газрын хамгийн их хохирол учруулсан хүчин зүйл бол өвчин, хортон шавьжинд идэгдсэн талбай байна. Өөрөөр хэлбэл нийт хохирол учирсан талбайн 79.1 хувь буюу 195674.5 га газар өвчин, хортон шавьжинд идэгдсэн байна.

Хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл түймэрт нэрвэгдсэн 26685.4 га (12.7%), мод бут, сөөг, загийг устгасан 15944.4 га (7,6%), ашигт малтмалын олборлолтод өртсөн 1012.6 га (0.5%) гэсэн дараалалтай байна.



Зураг 2.5.4.1: Ойн сан бүхий газарт учирсан хохирол, га-аар

Архангай, Завхан, Сэлэнгэ аймагт хамгийн их хохирол учирсан байна.


2.5.5. УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР

Усны сан бүхий газрын хохирлын тайланг гадаргын болон гүний ус бохирдсон, үйлдвэрийн хордолт, бохирдолтод өртсөн эрэг хавийн газар, ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн газар, бусад гэсэн 4 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 175.3 га усны сан бүхий газарт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 0.002 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 5881.3 га-аар бага байна.

Усны сан бүхий газрын хамгийн их хохирол учирсан талбай бол ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн газар байна. Өөрөөр хэлбэл нийт хохирол учирсан талбайн 66.1 хувь буюу 115.9 га газар ашигт малтмалын олборлолтод өрсөн байна.

Хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл бусад 40.6 га (23.2%), гадаргын болон гүний ус бохирдсон 18.8 га (10.7%) гэсэн дараалалтай байна.



Зураг 2.5.5.1: Усны сан бүхий газарт учирсан хохирол, га-аа

Дархан-Уул, Говь-Алтай, Хэнтий аймагт хамгийн их хохирол учирсан байна.


2.5.6. УХАГДАЖ ЭВДЭРСЭН ГАЗАР

Ухагдаж эвдэрсэн газрыг геологийн эрэл хайгуулын ажлаас, ашигт малтмалын олборлолтоос, батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны улмаас, барилга, инженерийн шугам сүлжээ барих, засвар үйлчилгээ хийх ажлаас, зам тээвэр холбооны барилга засвар, үйлчилгээний ажлаас гэсэн 5 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 18272.0 га газар ухагдаж эвдэрсэн нь нийт хохирол учирсан талбайн 0.25 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 14525.5 га-аар илүү байна.

Ашигт малтмалын олборлолтын улмаас хамгийн их талбай ухагдаж эвдэрсэн байна. Өөрөөр хэлбэл ухагдаж эвдэрсэн газрын 87.4 хувь буюу 15976.5 га газар ашигт малтмалын олборлолтод өрсөн байна.

Хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл зам тээвэр холбооны барилга засвар, үйлчилгээний ажлаас 1429.4 га (7.8%), геологийн эрэл хайгуулын ажлаас 678.0 га (3,7%), батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны улмаас 108.2 га (0,6%), барилга, инженерийн шугам сүлжээ барих, засвар үйлчилгээ хийх ажлаас 79.9 га (0,4%) гэсэн дараалалтай байна.



Зураг 2.5.6.1: Ухагдаж эвдэрсэн газар, га-аар

Нийслэл болон Өмнөговь, Сэлэнгэ аймагт газар хамгийн их ухагдаж эвдэрсэн байна.

Улсын хэмжээнд нийтдээ 18272.0 га газар ухагдаж эвдэрсэн нь нийт хохирол учирсан талбайн 0.25 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 14525.5 га-аар илүү байна.

2.6. ГАЗАР ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН /МАЯГТ ПТ-7/


2018 онд улсын хэмжээнд нийт 2759662,7 га газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг авсан байна. Үүнийг дотор нь ангилан үзвэл тариалангийн 177480,9 га, бэлчээр ба бусад өвслөг ургамал газрын 2348454,9 га, хот тосгон, бусад суурин газрын 26547,9 га, ойн сан бүхий газрын 203751,7 га, усны сан бүхий газрын 2110,8 га газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг авсан бол 1316,4 га газрыг уурхайн эдэлбэр газарт нөхөн сэргээх арга хэмжээг авсан байна.

2.6.1. ТАРИАЛАНГИЙН ГАЗАР

Тариалангийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг олон наст ургамал тарьсан, зурваслан тариалсан, ойн зурвасаар хамгаалагдсан, химийн бордоогоор бордсон, шим ба эрдэс бордоогоор бордсон, хортон шавьж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн гэсэн 6 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 177480.9 га тариалангийн талбайд хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан нь нийт талбайн 6.4 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 1944.8 га-аар илүү байна.

Тариалангийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газрын дийлэнх хэсгийг хортон шавьж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн талбай эзэлж байна.



Зураг 2.6.1.1: Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан тариалангийн газар, га-аар


Сэлэнгэ, Төв, Завхан, Дархан-уул аймагт тариалангийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан байна.

2.6.2. БЭЛЧЭЭРИЙН ГАЗАР

Бэлчээрийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг элсний нүүлтээс хамгаалсан, тордон сайжруулсан, хортон шавьж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн, хог хаягдлаас цэвэрлэсэн, даацыг зохицуулсан, ашиглалтаас чөлөөлсөн, сэлгэж ашигласан гэсэн 7 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 2348454.9 га бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан нь нийт талбайн 85.1 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 728456.9 га-аар илүү байна.

Бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газрын дийлэнх хэсгийг сэлгэж ашигласан талбай эзэлж байна.



Зураг 2.6.2.2: Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан бэлчээрийн газар, га-аар

Баянхонгор, Төв, Увс аймагт бэлчээрийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан байна.

2.6.3. ХОТ ТОСГОН, БУСАД СУУРИНЫ ГАЗАР

Хот, тосгон, бусад суурины газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг хөрсжүүлж зүлэгжүүлсэн, мод бут сөөг тарьсан, далан хаалтаар хамгаалсан, нүх, гуу жалгыг тэгшилж янзалсан, ахуйн хог хаягдлаас цэвэрлэсэн, үйлдвэрийн хог хаягдлаас цэвэрлэсэн, элсний нүүлтээс хамгаалсан, химийн болон цацраг идэвхт бодисоос цэвэрлэсэн гэсэн 8 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 26547,9 га хот, тосгон, бусад суурины газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан нь нийт талбайн 0.9 хувийг эзэлж байна. Энэ нь урьд онохоос 4908.6 га-аар илүү байна.

Хот, тосгон, бусад суурины газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газрын дийлэнх хэсгийг ахуйн хог хаягдлаас цэвэрлэсэн талбай эзэлж байна.



Зураг 2.6.3.1: Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан хот тосгон, суурин газар, га-аар

Хөвсгөл, Дундговь, Өвөрхангай аймагт хот тосгон, бусад суурины газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан байна.

2.6.4. ОЙН САН БҮХИЙ ГАЗАР

Ойн сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг ойн цэвэрлэгээ хийсэн, өвчин хортон шавьжтай тэмцэх арга хэмжээ авсан, мод бут сөөг шинээр тарьсан, нөхөн суулгалт хийсэн гэсэн 3 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 203751.7 га ойн сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан нь нийт талбайн 7.4 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 83236.4 га-аар илүү байна.

Ойн сан бүхий газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газрын дийлэнх хэсгийг өвчин, хортон шавьжтай тэмцэх арга хэмжээ авсан талбай эзэлж байна.



Зураг 2.6.4.1: Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан ойн сан бүхий газар, га-аар


Төв, Сэлэнгэ, Архангай аймагт ойн сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан байна.

2.6.5. УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР

Усны сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг ус, усан орчныг цэвэрлэх, цэвэршүүлэх арга хэмжээ авсан, усны эх булаг, эрэг орчмын газрын хөрсийг цэвэрлэх, хамгаалах арга хэмжээ авсан, усны үер, эвдрэлээс хамгалах арга хэмжээ авсан гэсэн 3 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 2110.8 га усны сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан нь нийт талбайн 0.1 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 978.4 га-аар илүү байна.

Усны сан бүхий газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газрын дийлэнх хэсгийг ус, усан орчныг цэвэрлэх, цэвэршүүлэх арга хэмжээ авсан талбай эзэлж байна.



Зураг 2.6.5.1: Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан усны сан бүхий газар, га-аар

Нийслэл болон Төв, Сэлэнгэ аймагт усны сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг авсан байна.


2.7. ГАЗРЫН ТӨЛБӨР НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТ /МАЯГТ ГТ-8/

Улсын хэмжээнд 2018 онд Газрын төлбөрийн тухай хууль болон Засгийн газрын 1997 оны “Газрын төлбөрийн хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 152 дугаар тогтоол, ГХБГЗЗГ /хуучин нэрээр/-н даргын 2011 оны “Газрын төлбөр ногдуулах аргачилсан заавар” 531 дүгээр тушаал, ГХБГЗЗГ /хуучин нэрээр/-ын, ТЕГ-ын хамтарсан 2012 оны “Газрын төлбөр, албан татвар төлөгчийн мэдээллийн санг хөтлөх, мэдээ, тайлан солилцох журам” 01/01 дүгээр тушаалын дагуу газрын төлбөрийг ногдуулж, төвлөрүүлж байна. Газрын төлбөрийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш газрын төлбөрийн орлогоос орон нутгийн төсөвт өссөн дүнгээр нийт 536 тэрбум 251 сая төгрөгийг төвлөрүүлээд байна /Хүснэгт 2.7.1, Зураг 2.7.1/.

Хүснэгт 2.7.1: Газрын төлбөрийн гүйцэтгэл /он тус бүрээр/

Он	Газрын төлбөрийн төлөвлөгөө / сая.төг/	Гүйцэтгэл / сая.төг/	Гүйцэтгэл /%/
1998	1919.6	1524.5	80
1999	2678.6	1764.2	66
2000	3221.5	2895.0	90
2001	4673.6	5401.9	116
2002	5570.7	6163.1	110
2003	7303.4	7962.0	109
2004	11840	11795.2	99
2005	13867.6	14045.2	101
2006	14323.0	15780.7	110

2007	19786.8	20093.7	102
2008	24790.4	25543.4	102
2009	28006.6	29472.4	105
2010	29311.7	30448.6	104
2011	31280.7	33556.8	107
2012	39031.3	43623.2	112
2013	37912.0	43185.1	114
2014	42326.9	44950.9	106
2015	45712.6	44556.2	97
2016	47002.6	46940.4	99.9
2017	47683.4	49361.9	103.5
2018	48875.9	51616.9	105.6
Нийт	507168.8	530681.0	




Зураг 2.7.1. Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /он тус бүрээр/

Тайлант оны байдлаар улсын хэмжээнд газрын төлбөрийн орлогоос нийт 51 тэрбум 616.93 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө 2 тэрбум 691.06 сая төгрөгөөр давж биелсэн бөгөөд гүйцэтгэл 105.6 хувьтай байна /Хүснэгт 2.7.2/.


Тайлант оны газрын төлбөрийн орлогыг өмнөх онтой харьцуулахад 2 тэрбум 255.01 сая төгрөгөөр өссөн дүнтэй байгаа нь жил ирэх бүр газар эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдийн тоо нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Хүснэгт 2.7.2. Аймаг, нийслэлийн 2018 оны газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний биелэлт

№	Аймаг, Нийслэл	Төлөвлөгөө (мян.төг)	Гүйцэтгэл (мян.төг)	Гүйцэтгэл /хувиар/
1	Архангай	45000.0	51785.9	115.1
2	Баянхонгор	124000.0	124419.5	100.3
3	Баян-Өлгий	102900.0	109804.0	106.7
4	Булган	189512.5	195162.3	102.9
5	Говь-Алтай	199290.4	192874.0	96.8
6	Говьсүмбэр	132000.0	170852.0	129.4
7	Дархан-Уул	742700.0	702100.0	94.5
8	Дорнод	410000.0	482405.5	117.7
9	Дорноговь	460000.0	514967.7	111.9
10	Дундговь	180000.0	178366.7	99.1
11	Завхан	195000.0	354392.4	181.7
12	Орхон	8300000.0	8327481.2	100.3
13	Өвөрхангай	111051.4	146343.0	131.8
14	Өмнөговь	3525100.0	4250459.7	120.6
15	Сүхбаатар	120000.0	160662.8	133.9
16	Сэлэнгэ	392887.4	428538.3	109.1
17	Төв	1485129.2	1561948.7	105.2
18	Увс	145000.0	145087.3	100.0
19	Ховд	154300.0	149506.7	96.9
20	Хөвсгөл	210000.0	211501.7	100.7
21	Хэнтий	152000.0	167110.5	109.9
22	Улаанбаатар	31500000.0	32991159.0	104.7
Нийт дүн		48875870.7	51616929.0	105.6



Зураг 2.7.2. Тайлант оны газрын төлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл /Орхон, Өмнөговь, Төв аймаг, нийслэлээс бусад/



Зураг 2.7.3. Тайлант оны газрын төлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл /Орхон, Өмнөговь, Төв аймаг, нийслэл/

2018 оны газрын төлбөрийн орлогын гүйцэтгэлийг аймаг, нийслэл тус бүрээр авч үзвэл Говь-Алтай, Дархан-Уул, Дундговь, Ховд аймгуудаас бусад аймаг, нийслэл нь газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг 100.0-181.7 хувийн гүйцэтгэлтэйгээр давуулан биелүүлсэн байна.


Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн аймаг, нийслэлийн Газрын албаны хувьд хууль тогтоомжийн дагуу газрын төлбөрийг газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж бүрт ногдуулж, хураан барагдуулах ажлыг батлагдсан журам, зааврын дагуу хэрэгжүүлэн ажиллав.

Мөн газрын төлбөрийн өр барагдуулах дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- Газар эзэмших, ашиглах гэрээний нөхцөл болзлын дагуу гэрээг дүгнэх;
- Газрын төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх, тасалдаж байгаа орлогын хэмжээг нэмэгдүүлэх, төлбөр барагдуулалтын талаарх мэдээ, газар эзэмших, ашиглах гэрээг дүгнүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудас зэргээр зар сурталчилгаа явуулах;
- Газрын төлбөр барагдуулах тодорхой хугацааны аян зохион байгуулах;
- Тодорхойгүй орлогын талаар арилжааны банкуудтай хамтран ажиллах;
- Газрын төлбөрийн их хэмжээний өртэй аж ахуйн нэгж, байгууллагыг шүүхэд нэхэмжлэх гарган газрын төлбөрийг барагдуулах.


Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй аймгуудын хувьд:

- Эзэмшил газраа 2 жил дараалан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ашиглаагүй, газрын төлбөрийг цаг хугацаанд нь төлөөгүй зэргээр Газрын тухай хууль болон газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй газар эзэмшигч, ашиглагч нарт тухайн шатны Засаг даргын шийдвэрээр газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгон хариуцлага тооцон холбогдох төлбөр тооцоонд хасалт хийгдсэн;
- Уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа зогсоож төсөв хөрөнгө байхгүй шалтгаанаар газрын төлбөр төлөхгүй байх;
- Мал бүхий иргэд бэлчээрийн газрын төлбөрийг төлдөггүй зэрэг шалтгааны улмаас газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг тасарсан гэж үзэж байна.



Зураг 2.7.4: Тайлант оны газрын төлбөрийн орлогын гүйцэтгэл /хувиар/

2018 онд газрын төлбөрөөс орон нутгийн төсөвт оруулсан орлогыг газрын нэгдмэл сангийн ангиллаар авч үзвэл хамгийн их хувийг хот тосгон, бусад суурины газар болон тусгай хэрэгцээний газар, хамгийн бага хувийг усны сан бүхий газар, зам, шугам сүлжээний газрын төлбөр эзэлж байна. Энэ нь хот суурин газрын эрх зүйн харилцаа үүссэн нэгж талбарын тоо бусад ангиллын эрх зүйн харилцаа үүссэн нэгж талбарын тооноос харьцангуй их байгаатай холбоотой юм /Зураг 2.7.5/.



Зураг 2.7.4: Газрын төлбөрийн орлого төвлөрүүлэлт /Газрын нэгдмэл сангийн ангиллаар, хувиар/

Тулгамдаж буй асуудал:

- Газрын төлбөрийн тухай хуулинд газрын төлбөрийг Газрын албаны мэргэжилтэн, газрын даамал хураан төсөвт төвлөрүүлнэ гэж заасан байдаг. Гэвч дээрх албан хаагчид байцаагчийн эрхгүйгээс шалтгаалан хураах, төвлөрүүлэх эрх зүйн чадамжгүй байдаг.

- Аймгийн хэмжээний газрын төлбөрийн орлогыг төвлөрүүлж буй данс / төрийн сангийн данс/ нэг байдагтай холбоотойгоор газар эзэмшигч, ашиглагчийн нэрээр бус төлбөр тушаагч иргэний нэрээр тэмдэглэх, аль сумаас орлого орж байгаа нь тодорхойгүй байх зэргээс шалтгаалан сум тус бүрээр барагдуулалтыг гаргаж төлбөр хянахад хүндрэл гарч байна.

- Газрын төлбөрийн ногдуулалт дээр үндэслэлгүйгээр орлогын төлөвлөгөөг Сангийн яамнаас зохиомлоор нэмэх байдал гарч байгаа нь орлого бүрэн төвлөрөхгүй байх шалтгаан болж байна.

-

Мөн аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Газрын алба нь газрын төлбөрийг ногдуулан хурааж улсын төсвийг бүрдүүлэхэд багагүй хувь нэмэр оруулж байгаа хэдий ч Газрын төлбөрийн тухай хуулийн 10.2-д заасан газар зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх зардлын эх үүсвэргүйгээс төрийн өмчийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх, түүний төлөв байдал чанарыг тодорхойлж тасралтгүй хянаж байх үйл ажиллагаа алдагдах, газар зохион байгуулалтын төлөвлөгөө хэрэгжихгүй байгаагаас газрын зөрчил маргаан гарах нөхцөл шалтгаан болж байна. Иймд дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн эх үүсвэр шаардлагатай байх бөгөөд үүнийг зохих хуулийн хүрээнд газрын төлбөрийн орлогын хэсгээс санхүүжүүлэх нь зүйтэй байна.

Авч хэрэгжүүлж буй арга хэмжээ:

Аймгийн хэмжээнд газрын төлбөрийн орлогыг төвлөрүүлдэг данс нэг байдагтай холбоотойгоор сум тус бүрийн газрын төлбөрийг тодорхой гаргаж, төлбөрийг нэгж талбар тус бүрээр ногдуулж барагдуулах, хэд хэдэн газартай газар эзэмшигчийн газрын төлбөрийн давхардлыг арилгах, хянах зорилгоор сар бүр газрын төлбөрийн хуулгыг боловсруулж, сумдын даамлуудтай харилцан мэдээлэл солилцож, ажлын уялдааг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй банкуудад төлбөр төлөгч иргэдийн сумын нэр, регистрийн дугаарыг давхар бичилт хийж өгөх талаар Газрын даргын албан тоотыг хүргүүлэн ажиллаж байгаа ба аймгийн Татварын хэлтсийн мэргэжилтнүүдтэй тодорхойгүй орлогын талаар өдөр бүр тогтмол холбогдож, газрын төлбөр барагдуулах тооцоо нийлэх асуудлаар хамтран ажиллаж байна.

Аймгуудын зүгээс урьд оны дутуу төлөлт, газрын төлбөрийг барагдуулах төлбөрийн гүйцэтгэлийг хангахын тулд аймаг, сумын Засаг дарга, Татварын хэлтэстэй хамтран Газрын төлбөр барагдуулах тодорхой хугацааны аян зохион байгуулах, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдэгдэл, мэдээлэл явуулж ажилласан ба үүрэн телефоны корпорацитай хамтран ажиллаж “Мобайл сурталчилгааны үйлчилгээ”-г нэвтрүүлэх гэрээ байгуулж, газрын төлбөр төлөгч иргэн, аж ахуйн нэгж байгуулагад текстэн зар хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан байна.

Ингэснээр аймгийн хэмжээнд нийтийг хамарсан мессежийг /текстэн зар/ газрын төлбөр төлөгч бүрт шуурхай хүргэж, газар эзэмших гэрээний нөхцөл болзлын дагуу гэрээгээ дүгнүүлэх, урьд онуудад төлж барагдуулаагүй өр авлагыг барагдуулахад томоохон ажлуудын нэг болсон байна.

Газрын тухай хууль болон газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээнд заасан нөхцөл болзлыг удаа дараа зөрчсөн тухайлбал эзэмшил газраа 2 жил дараалан хүндэтгэн үзэх шалгаангүйгээр ашиглаагүй, газрын төлбөрийг цаг хугацаанд нь төлөөгүй газар эзэмшигч, ашиглагч нарт холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх мэдэгдлийг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хүргүүлэн ажилласан.

Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр дур мэдэн газар ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд газар ашигласан төлбөрийг ногдуулж, газрын төлбөрөө хугацаанд нь барагдуулаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад алданги /хүү торгууль/ тооцож, төсөвт төвлөрүүлсэн.

Мөн 2019 онд Газрын татвар, төлбөрийн системийг нэвтрүүлэхээр хөгжүүлэлтийн ажлыг хийж эхэлсэн бөгөөд тухайн систем бүрэн нэвтэрснээр газар эзэмшигч, өмчлөгч, ашиглагч нь төлбөрийн мэдээллээ интернетээр, гар утас, таблет ашиглан авах, газрын татвар, төлбөрөө “Газрын татвар, төлбөрийн систем”, мобайл банк, гар утасны аппликейшн зэргийг ашиглан төлөх боломж бүрдэх юм.

Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолоор батлагдсан газрын суурь үнэлгээг “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор шинэчлэн баталсантай холбоотойгоор Газрын төлбөрийн тухай хуульд заасны дагуу 330 сум, 9 дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх хил зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утгыг батлуулах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

2.8. ГАЗАР ӨМЧЛӨЛИЙН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-9/

2018 оны байдлаар Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу улсын хэмжээнд өссөн дүнгээр нийт 615454 иргэний 62217.34 га газрын өмчлөх эрхийг баталгаажуулсан байна.


